

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2021 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2021.11.03

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит V Хуралдаан 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хуралдаж 3 асуудал хэлэлцэн 3 тогтоол баталлаа. Үүнд:

1. Комисс байгуулах тухай асуудлыг хэлэлцээд Орхон, Сайхан сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах санал боловсруулах комиссыг байгууллаа.

2. 2022 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай асуудлыг хэлэлцээд сум тус бүрээр хэлэлцэн баталлаа.

3. Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын V хуралдаанд оролцсон 36 төлөөлөгчийн 19 буюу 52.7 хувийн саналаар дэмжигдсэн Нацагдоржийн Лхагвадоржийг аймгийн Засаг даргаар томилуулахаар Монгол Улсын Ерөнхий сайдад санал болголоо.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид 2021 оны 11 дүгээр сард 2 удаа хуралдаж 20 асуудал хэлэлцэж 11 тогтоол баталлаа. Үүнд:

1. Хуралдааны тов тогтоох тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын V хуралдааныг 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хуралдуулж 3 асуудал хэлэлцүүлэхээр тогтоов.

2. Үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах тухай асуудлыг хэлэлцээд зарим байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, сэргээн засварлах боломжгүй болсон тээврийн хэрэгслүүдийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг тогтоолоо.

3. Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд зарим сум, байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, сэргээн засварлах боломжгүй болсон барилга, тоног төхөөрөмжийг акталж, данснаас хасахыг зөвшөөрөв.

4. Үндсэн хөрөнгө шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцээд Орхон сумын ЕБС-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй дотуур байрыг Орхон сумын ЗДТГ-т шилжүүлэхийг зөвшөөрөв.

5. Зарим хүмүүсийг шагналд уламжлах тухай асуудлыг хэлэлцээд Ардын хувьсгалын 100 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа үр бүтээлтэй ажилласан хүмүүсийг төрийн одон, медалиар шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 5, Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор 1, Алтан гадас одонгоор 12, Цэргийн гавьяаны одонгоор 1, Хөдөлмөрийн хүндэт медалиар 30 хүнийг шагнуулахаар уламжлав.

6. Хуралдаан зарлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын ээлжит VI хуралдааныг 2021 оны 12-р сарын 03-ны өдөр хуралдуулж 9 асуудал хэлэлцүүлэхээр тогтоов.

7. Хөдөө аж ахуйн салбарын хөгжил дэвшлийг манлайлан, газар тариалан, мал аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх үйлсэд Цагааннуур сумын ард иргэд, аж ахуйн нэгж, малчид, тариаланчдын оруулж байгаа хувь нэмэр, хөдөлмөр бүтээлийг нь үнэлж Цагааннуур сумыг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагналаа.

8. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим иргэдийг шагнаж урамшууллаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ахмад ажилтан Лхамсүрэнгийн Баасанжав, Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ангийн жолооч Цэдэвсүрэнгийн Нармандах, Хушаат сумын ахмад настан Баасангийн Алтбазар нарыг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнав.

9. Шүүхийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Дамдинжавыг Мөнхцэцэгийг Алтан гадас одонгоор шагнуулах саналыг дэмжин Монгол Улсын Шүүхийн Ерөнхий зөвлөлд санал уламжиллаа.

10. Улс орон даяар зохион байгуулагдаж буй аж ахуйн нэгжийн улсын бүртгэл тооллоготой холбогдуулан Сэлэнгэ аймгийн Үндэсний бөхийн холбоог шинэчлэн зохион байгуулах тухай Улаанбаатар хот дахь Сэлэнгэ аймгийн Нутгийн зөвлөлөөс ирүүлсэн саналыг дэмжив. Шинэчлэн зохион байгуулсан Сэлэнгэ аймгийн Үндэсний бөхийн холбооны дэргэд бөхийн спортын төрлүүдийг нийтэд сурталчлан таниулах, бөхийн спортоор сонирхон хичээллэгч хүүхэд залуусыг дэмжиж, сурган дасгалжуулах үүрэг чиглэл бүхий “Таван Хан Ноён” бөхийн дэвжээг байгуулах нь зүйтэй гэж үзлээ.

Мөн Тэргүүлэгчдийн хуралдаанаар:

1. 2021-2022 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлын тухай
2. Өвөлжилтийн бэлтгэл ажлын тухай
3. Алтанбулаг боомтын шинэчлэлийн ажлын талаарх мэдээлэл
4. Бид Сэлэнгийн ирээдүй хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухай
5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд хамгааллын талаар авч хэрэгжүүлж буй ажил арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх

6. “Цант-Орхон”, “Сэлэнгэ энерго”, “Сэлэнгэ орон сууц”, “Цэнгэг ус”, “Гавшгай ус”, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-уудын 2020, 2021 оны үйл ажиллагааны тайлангийн тухай тус байгууллагуудын дарга удирдлагын мэдээллүүдийг сонслоо.

Тулгар төр байгуулагдсаны 2230 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 815 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ой, Улс тунхагласны 97 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг тохиолдуулан төрийн захиргаа, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, газар тариалан, мал аж ахуй, боловсрол, эрүүл мэнд, хууль хяналт, хил хамгаалах байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан Сэлэнгэ аймгийн харьяат хүмүүсийг Монгол Улсын одон медалиар шагнах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 99 дүгээр зарлигаар шагнасныг гардуулан өглөө.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор Бүгд Найрамдах улс тунхагласны түүхэн ойн баярын өдрийг тохиолдуулан зохион байгуулдаг “Иргэний андгай өргөх ёслол”-ын арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Арга хэмжээнд 16 нас хүрч Монгол Улсын иргэний үнэмлэхээ гардан авч буй 300 хүүхдээс Сүхбаатар сумын сурлага хөдөлмөрөөрөө тэргүүлж, амжилттай суралцаж буй 50 сурагчийг төрийн тайзнаа алдаршуулан иргэний үнэмлэхийг нь батламжлан гардууллаа.

Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтад тэнцэж журмын дагуу өөрсдийн эрхэлж буй төрийн захиргааны албан тушаалын чиг үүрэг, түүнд тавигдах шаардлагыг ханган ажиллаж буйг үндэслэн нэр бүхий албан хаагчид төрийн захиргааны албан хаагчийн ТАНГАРАГ өргөлөө.

УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын хэсэг /ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан гишүүдэд УИХ-ын гишүүн Т.Аубакир, Г.Дамдинням, Н.Ганибал, Ж.Батжаргал, ХХААХҮЯ-ны баг бүрэлдэхүүн/ манай аймагт ажиллаж Хүнсний тухай хуулийн хэрэгжилт, стратегийн хүнс болох улаанбуудайн ургацын байдал, нөөц бүрдүүлэлт, борлуулалт, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, хангалтын байдал, үр шинэчлэлт хангамжийн талаар хяналт шалгалт хийж, санал дүгнэлт гаргалаа.

УИХ-ын гишүүн Ч.Ундрам аймгийн сумдад нэн шаардлагатай байсан хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат, суурин компьютерыг хүн амын тоотой нь харьцуулж хүлээлгэн өглөө. Аймгийн Эрүүл мэндийн төвүүд болон Ерөө, Жавхлант, Шаамар, Хүдэр, Хушаат сум Дулаанхаан тосгоны эрүүл мэндийн төвийн төлөөлөл хүлээн авлаа.

Төрийн албаны тусгай шалгалтыг 2021 оны 11-р сарын 2-4-ний өдрүүдэд зохион байгууллаа. Энэ удаагийн тусгай шалгалтад төрийн захиргааны удирдах албан тушаалын 6, гүйцэтгэх албан тушаалын дэс түшмэлийн 65, туслах түшмэлийн 39, нийт 110 сул орон тоо зарлагдсанаас удирдах албан тушаалын 4, дэс түшмэлийн 45, туслах түшмэлийн 14 сул орон тоог нөхөх арга хэмжээ авлаа.

Төрийн албаны ерөнхий шалгалтад Сэлэнгэ аймгаас орох 234 иргэн бүртгэгдэж, 11 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын их танхимд зохион байгууллаа. Шалгалтад нийт 234 иргэн оролцохоос 185, ирц 79,0 хувьтай, оролцсон нийт 185 иргэнээс 63 иргэн буюу 34,0 хувь нь тэнцэж, нөөцөд бүртгэгдлээ.

“Цогц чадамжийг нэвтрүүлэх нь-Ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх, хүний нөөцийн мэргэжилтнийг чадавхжуулах нь” сэдэвт Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Хөвсгөл, Булган аймгийн төрийн албан хаагчдыг оролцуулсан төвийн болон хангайн бүсийн сургалтыг Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Иргэн төвтэй, мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэх” төсөлтэй хамтран 2021 оны 11 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын их танхимд зохион байгууллаа. Сургалтад нийт 71 албан хаагч оролцсон.

Засгийн газрын “Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 2019 оны 149 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2019 онд 17 суманд төрийн үйлчилгээг операторын горимоор цахимаар түргэн шуурхай хүргэх үйлчилгээг амжилттай нэвтрүүлж 1 шатлалт 54 үйлчилгээг үзүүлж байсан бол Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын “E-Mongolia” төслийн нэгжтэй хамтран 2 шатлалт үйлчилгээний сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгуулж, аймгийн хэмжээнд 15 байгууллагын 73 нэр төрлийн 269 үйлчилгээг нэвтрүүллээ.

Нийгмийн тулгамдсан асуудал болох хүүхдийг цахим донтолтоос сэргийлэх үндсэн зорилготой “Дэлгэцийн донтолтоос сэргийлж, эрүүл мэндээ хамгаалцгаая” төслийг аймгийн Засаг даргын тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас “Эерэг өөрчлөлтийн түүчээ” ТББ-тай хамтран хэрэгжүүлж албан ёсоор нээлт хийж, нээлтэд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр захиргааны

байгууллагууд, багш сурагчид, эцэг эхчүүдийн төлөөлөл нийт 200 гаруй хүн оролцож, сургалт хичээлд хамрагдлаа.

Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабаас дэлхийн дахинд тархаад буй коронавирус /Ковид-19/-ын халдварын тохиолдол гарч, халдварлах эрсдэл бий болсонтой холбоотойгоор урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр Онцгой комиссын орлогч, Шуурхай штабын дарга, дэд хурандаа Г.Галбадрахаар ахлуулсан Онцгой байдлын газар 7, Цагдаагийн газар 1, Мэргэжлийн хяналтын газар 4, Эрүүл мэндийн газраас 1 нийт 13 албан хаагч өглөөний 09:00-21:00 цаг хүртэл ажиллан дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын даргаас хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар өгсөн үүрэг чиглэл, мэргэжлийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн арга хэмжээ, нөхцөл байдлын мэдээллийг хүлээн авч холбогдох шийдвэрийг гаргаж, сумдын Онцгой комиссын дарга нарт үүрэг чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шуурхай штабын **70363684, 70360119** дугаарын утсанд **360** мэдээлэл, цахим хаягаар **115** албан бичиг, гар өргөдөл **10** нийт **485** мэдээллийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас болон Онцгой байдлын газрын цахим цахим хуудсанд Онцгой байдлын газар, “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-тай хамтран “Яагаад амны хаалт зүүх ёстой вэ?”, “Гараа яагаад угаах ёстой вэ?”, “Хамтын хүчээр халдвараас сэргийлье”, “Ковидгүй Сэлэнгийн төлөө” Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулсан сэрэмжлүүлэг шторк 5-ыг бэлтгэн, **92** удаа мэдээ, мэдээлэл байршуулж **102.000** хандалт авсан.

Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг шуурхай бэлтгэн аймгийн Засаг даргын Тамгын газраас “Сэлэнгэ аймаг АЗДТГ”, “Сэлэнгэ Цахим телевиз” цахим хуудас, Зиндаа.мн сайт, Улс төрч.мн сайт, Сүхбаатар сум дахь лед дэлгэц, орон нутгийн “Миний Монгол ТВ”, “Таны Сэлэнгэ ТВ” мөн МҮОНТ-ийн ММ агентлаг, Өлзий телевиз, Монцамэ агентлаг зэрэг мэдээллийн сувгуудаар мэдээ, мэдээллийг дамжуулан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Онцгой комиссын шуурхай штаб, Онцгой байдлын ерөнхий газарт тухай бүр мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын 1 дүгээр давлагаанд **217**, 2 дугаар давлагаанд **17817** нийт **18034** тохиолдолд батлагдаж 2021 оны 11 дүгээр сарын байдлаар **17145** иргэн эдгэрч, **52** хүн нас барж, 12 ковидын эмчилгээний тасагт **166** иргэн хэвтэн эмчлүүлж, гэрийн эмчилгээнд **408** иргэн өрх болон сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн хяналтад байна.

Хэвтэн эмчлүүлж байгаа иргэдээс маш хүнд **1**, хүнд **9**, хүндэвтэр **68**, хөнгөн **88**, үүнээс жирэмсэн **10**, 0-17 насны **27** хүүхэд байна.

Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нэгдүгээр тун **69755**, хоёрдугаар тун **65645**, /аймгийн хэмжээнд зохион байгуулсан дархлаажуулалтын нэмэлт тунд хамрагдах аяны хүрээнд 11 дүгээр сард **6319** хүн хамрагдсан/ гуравдугаар тун **25344** тус тус хийгдээд байна.

Илрүүлэлтийн явц: Аймгийн хэмжээнд 11 дүгээр сард коронавируст халдвар /ковид-19/-ын **2522** тохиолдол шинээр бүртгэгдэж, **3708** хүн эдгэрч, **15** нас баралт бүртгэгдэж, сүүлийн 2 сарын хугацааг харьцуулж үзвэл батлагдсан тохиолдол 56 хувь буурсан байна.

Хавьталын тоо: Аймгийн хэмжээнд **18034** тохиолдол батлагдсанаас ойрын хавьтал **11846**, дам хавьтал **5707**, нийт **17553** ойрын болон дам хавьтал тогтоогдож байна.

Энэ хугацаанд **23** хяналтын цэгт давхардсан тоогоор **600** Цагдаагийн газрын албан хаагч **23** тээврийн хэрэгсэлтэй, Онцгой байдлын газрын **900** алба хаагч, Эрүүл мэндийн байгууллагын **1470**, Мэргэжлийн хяналтын газрын **30** бусад төрийн байгууллагуудтай хамтран нийт **3000** албан хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Аймгийн хэмжээнд **1185** цэг байршилд **868,379** м2 талбайд урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн хэмжээнд шатахуун тээвэрлэлт орох чиглэлд **2**, гарах чиглэлд **3**, хүнс тээвэрлэлт орох чиглэлд **3**, гарах чиглэлд **4**, малын өвс тэжээл, үр тариа орох чиглэлд **24**, гарах чиглэлд **12** тээврийн хэрэгсэл хөдөлгөөн үйлдсэн байна.

Малын гоц халдварт өвчний талаар: Аймгийн хэмжээнд мал, амьтны гоц халдвар “Шүлхий” өвчний 8 голомтод хорио цээрийн дэглэм тогтоон ажиллаж байна.

Өвчлөл бүртгэгдсэн өдрөөс эхлэн нийт **294** өрхийн **745** хонь, **108** ямаа, **2883** үхэр нийт **3897** мал, амьтанд гоц халдварт А01 өвчний шинж тэмдэг илэрч, зэмэгжүүлэн бүртгэлжүүлсэн.

Улсын Онцгой комисс болон Мал эмнэлгийн ерөнхий газраас 4 удаагийн татан авалтаар **330,400** тун вакцин хүлээн авч одоогийн байдлаар **2719** өрхийн **90026** үхэр, **384620** бог, **2097** гахай нийт **476743** толгой мал, амьтныг вакцинжуулалтад хамруулж, вакцинжуулалт **92,4** хувьтай хийгдсэн.

Нийт **835** малын хашаа хороо, тоног хэрэгсэл, бэлчээрийн **917464** м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд мал амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний дуудлага **8**, объектын гал түймэр **8**, аврах ажиллагаа **2**, усны осол **1** удаагийн дуудлагаар тус тус гарч ажилласан.

Объектын гал түймрийн 8 удаагийн дуудлагаар 25,300,000 төгрөгийн хохирол учирч иргэн аж, ахуй нэгжийн 2,640,000,0 төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна. /объектын гал түймэрт түлэгдсэн, нас барсан тохиолдол байхгүй/

Онцгой байдлын Ерөнхий газрын даргын баталсан “Зоорийн давхарийн барилга”-д Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалтыг “Коронавируст халдвар /ковид-19/-аас сэргийлэх, арга хэмжээг зохион байгуулах,” түр журмыг мөрдлөг болгон коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр үзлэг шалгалтыг 8 объект хамруулан 28 иргэнд сэрэмжлүүлэг өгч 16 зөрчил илрүүлж 10 зөрчлийг газар дээр нь арилгуулан ажиллалаа.

Онцгой байдлын газрын дарга, “Дархан, Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК, “Дэлхийн зөн Монгол” ОУБ-тай хамтран “Гэр, байшингийн цахилгааны хэрэгслийн галын аюулгүй байдлыг хангуулах” нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу Онцгой байдлын газрын 19, 36, 40, 61, ЭХАА, ЭХАС нар14 хоногийн хугацаатай ГАУС үзлэг шалгалт, сэрэмжлүүлгийг Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан, Хүдэр сумдын **23** багийн нутагт оршин суух **2113** айл өрх хийн ажиллалаа.

Үзлэг шалгалтаар: Нийт 2113 айл өрх хамрагдаж **756** зөрчил дутагдал илрүүлэн **308** зөрчлийг газар дээр арилгаж, дээрх айл өрхүүдэд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, зөрчлөө арилгуулах талаар шаардлага тавьж элэгдэлд орсон, гэмтэлтэй

цахилгааны утсыг ашиглахгүй байх, галын аюулгүй байдлын шаардлагыг хангуулах,эвдрэл гэмтлийг арилгах заавар, зөвлөмж өгч, **6339** иргэнд сэрэмжлүүлэг сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:

2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 21 хяналтын чиглэлээр 299 объектод шалгалт хийхээр төлөвлөснөөс 235 буюу 78.5 хувьд /59 объектын үйл ажиллагаа зогссон, 5 объектод хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн боловч коронавирус цар тахлын улмаас хяналт шалгалт хийгдээгүй/, 115 объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөснөөс 93 объект буюу 80.6 хувьд /22 объектын үйл ажиллагаа зогссон/, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 42 объектод, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 286 объектод, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 46 асуудлын хүрээнд 1984 объектод, тандалт судалгааг 11 асуудлын хүрээнд 132 объектод, хяналт шинжилгээг 13 асуудлаар 150 объектод нийт 2922 объектод хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Эхний 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд давхардсан тоогоор үсчин, гоо сайхан, хумс заслын 150, нийтийн халуун ус, саун, бассейны 26, амралтын газар, жуулчны бааз 7, зочид буудал, дэн буудал үйл ажиллагаа эрхлэгч 26, биеийн тамир, спорт, чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээний 10, соёл урлаг, үзвэр үйлчилгээний 5, сүм хийд, шашны 8 байгууллага, хүнсний тээвэрлэлт 38, хүнсний 20 үйлдвэр, хүнсний 607 худалдаа газар, нийтийн хоол үйлдвэрлэл, хүргэлтийн үйлчилгээний 205, хүнсний бус бараа бүтээгдэхүүний зах, худалдаа эрхлэгч 251 нийт өссөн дүнгээр 1353 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх явцад нийт 5736 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 2035 буюу 35.5 хувийг арилгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор улсын байцаагчийн зөвлөмж, аймгийн Онцгой комиссын 08 дугаар тогтоол, сэрэмжлүүлгийг өгч, улсын байцаагчийн 14 төрлийн зөвлөмжийг 1137 объектод хүргүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын 1203 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмжийг өгч ажилласан.

Хяналт шалгалтын хүрээнд Ерөө, Хүдэр, Баянгол, Сүхбаатар, Орхонтуул, Түшиг, Сайхан сумдын нутагт хяналт шалгалт хийж зөрчил гаргасан 14 хуулийн этгээдэд 67.450.00 төгрөгийн торгууль, 26.218.673 төгрөгийн нөхөн төлбөр оногдуулснаас 64.450.000 төгрөгийн торгууль, 6.008.024 төгрөгийн нөхөн төлбөрийг барагдуулаад байна. Ерөө сумын 2-р багийн нутаг “Ялбаг” гэх газарт байрлах хяналтын постод түр хураагдаж саатуулагдсан аж ахуйн нэгж, иргэн нөхөрлөлийн нийт 57 техник хэрэгслээс 32 техник тоног төхөөрөмжийг буцаан олгохоос 11 дүгээр сарын байдлаар 1 аж ахуйн нэгж, 4 иргэнд 19 техник тоног төхөөрөмжийг буцаан олгосон.

Стандарт, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

“Чанарыг эрхэмлэх жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу аж ахуй нэгж, байгууллагуудад хэмжлийн үнэн зөв нэгдмэл байдлыг хангахтай холбогдох Монгол улсын “Хэмжил зүйн тухай” хууль, түүнтэй нийцүүлэн баталсан дүрэм, журам холбогдох стандартын хэрэгжилтийн болон болон хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, ашиглалтад хяналт тавих замаар эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зорилгоор хяналт шалгалтыг барилгын материал худалдан борлуулдаг “Сэлэнгэ титан”, “Алтан есүй” ХХК-ий барилгын дэлгүүр, “Арга билэг”, “ Хаш”, “Сибирь” барилгын дэлгүүрүүдэд явууллаа.

Мөн тус жилийн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу “Чанарыг эрхэмлэх нь” гар зургийн уралдааныг зарлан, уралдаанд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1, 2, 4 дүгээр сургууль, Ерөө сумын Бугант тосгоны ЕБС, Цагааннуур, Сайхан, Баянгол сумдын ЕБС, Мандал сумдын Хэрх тосгоны ЕБС-иудын нийт 25 сурагчийн 27 бүтээл ирүүлсэн байна.

Уралдаанд ирүүлсэн 27 гар зургийг аймгийн Боловсролын газрын арга зүйч Ундрах, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн зургийн багш Гансүх нарыг байлцуулан 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр хэлтсийн мэргэжилтнүүд харилцан ярилцаж зургийг шалгаруулж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, 9 бүтээл шалгаруулсан.

Үйлчилгээний баталгаажуулалт: 2 аж ахуйн нэгжийн 2 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж холбогдох стандартын шаардлага хангасан тул тохирлын гэрчилгээ олгосон.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 8 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 8 нэрийн 11 стандартын талаар мэдээлэл арга зүйн зөвлөмж өгч, 2 нэрийн 5 стандарт борлуулсан.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: 33 Шатахуун түгээх станцын 95 түгээгүүр, 1 эмнэлгийн жинд баталгаажуулалт хийсэн.

Механикийн хэмжлийн төрлөөр: 6 ширхэг худалдааны жинд шалгалт баталгаажуулалт хийсэн.

Дулаан даралтын хэмжлийн төрлөөр: 6 ширхэг цусны даралтын аппарат, 1 техникийн манометр шалган баталгаажуулсан.

Цахилгаан хэмжлийн төрлөөр: Айл өрх, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй 1 фазын 17 ширхэг цахилгааныг тоолуурыг шалган баталгаажуулсан.

Шалгалт тохируулга: 5 ширхэг усны тоолуурт шалгалт тохируулга хийсэн.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Тус сард 1677 баримтаар 12’584’376 мянган төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 10 сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн web сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

2022 оны төсвийн төслийг Сангийн ямаар батлуулахаар хуваарийн дагуу сумд болон байгууллагуудын төслийг хянуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу төсөвт байгууллагын санхүүгийн туслан зөвлөх ажлыг зохион байгуулж ажилласан.

Аймгийн Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу сумдад төрийн сангийн дотоод хяналтын ажлыг зохион байгуулж ажилласан.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	1. Орон нутгийн төсвийн нийт орлого	95,046,796.1	98,761,048.4	103.9
1.1	Орон нутгийн төсвийн орлого	22,007,961.2	29,774,669.6	135.3

	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	15,671,977.1	16,505,270.7	105.3
	Сумдын төсвийн орлого	6,335,984.1	13,269,398.9	209.4
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	4,220,453.8	4,220,453.8	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	45,571,229.0	45,571,229.0	100.0
1.4	Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг	546,964.0	483,637.1	88.4
1.5	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	9,288,969.3	8,263,037.0	89.0
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	7,108,996.3	7,108,996.3	100.0
1.7	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	2,299,871.5	1,734,326.7	75.4
1.8	Төсөвт байгууллагын өөрийн орлого	136,588.8	311,210.4	227.8
1.9	ОНХС-д хандив	1,430,000.0	10,000.0	0.7
1.10	Сум хөгжүүлэх сан /орлого/	2,435,762.2	1,283,488.5	52.7
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		94,366,796.1	74,945,040.0	79.4
		94,366,796.1	74,945,040.0	79.4
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	21,937,338.2	16,765,842.6	76.4
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	4,296,657.0	2,107,663.6	49.1
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	16,328,051.3	9,655,553.6	59.1
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	887,438.8	215,295.7	24.3
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	7,709,703.4	3,162,858.6	41.0
	Халамжийн сан	134,539.4	58,035.5	43.1
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	6,247,831.4	5,209,048.1	83.4
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	1,348,538.3	1,010,315.7	74.9
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	50,986,845.9	45,652,840.9	89.5
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	817,903.7	763,139.3	93.3
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		66,971,580.7	65,945,648.4	98.5
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	12,111,382.4	12,111,382.4	100.0
	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	3,061,309.1	3,061,309.1	100.0
3.2	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	117,785.0	117,785.0	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардалд	2,943,524.1	2,943,524.1	100.0
	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	6,227,660.2	5,201,727.9	83.5
3.3	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	5,886,509.6	4,860,577.3	82.6
	Усны татаас	319,500.0	319,500.0	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	21,650.6	21,650.6	100.0

3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	44,801,259.6	44,801,259.6	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	769,969.4	769,969.4	100.0
	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	45,571,229.0	45,571,229.0	100.0
3.6	- Ерөнхий боловсролын сургууль	24,411,606.6	24,411,606.6	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	12,494,771.2	12,494,771.2	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	7,774,044.0	7,774,044.0	100.0
	- Газрын кадастрын байгууллага	468,438.6	468,438.6	100.0
	- Хүүхдийн байгууллага	422,368.6	422,368.6	100.0
4. Тусгай сангуудын зарлага		2,435,762.2	1,283,488.5	52.7
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	2,435,762.2	1,283,488.5	52.7

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2020 10- сар	2021 10- сар	2021-10 2020-10 Х/төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА				
	Гурил /савласан, кг/	1 200	1 400	116.7
	Талх /орон нутгийн, ш/	1 300	1 400	107.7
	Нарийн боов /кг/	2 600	4 000	153.8
	Будаа /кг/	2 600	2 700	103.8
	Элсэн чихэр /кг/	2 000	2 500	125.0
2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН				
	Хонины мах /кг/	7 500	8500	121.4
	Үхрийн мах /кг/	8 000	9 500	118.8
	Адууны мах /кг/	6300	7500	119.0
	Ямааны мах /кг/	6000	7 500	125.0
	Дотор мах, цувдай /цусгүй/	4 000	5 000	125.0
	Хиам /чанасан, кг/	11 000	12 500	113.6
3 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ				
	Сүү /задгай, л/	900	1 400	155.6
	Сүү / савласан, л/	3 200	3350	104.7
	Тараг /задгай, л/	1 100	1 500	136.4
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	16 000	18 000	112.5
	Айраг /л/	4 000	5 000	125.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	5 500	122.2
	Өндөг /ш/	350	450	128.6
4 БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС				
	Ургамлын тос /л/	4 500	5 300	117.8
	Өөхөн тос /кг/	2 500	3000	120.0
	Шар тос /кг/	15 000	23 000	153.3
	Масло /задгай, кг/	4 500	5 000	111.1
5 ХҮНСНИЙ НОГОО				
	Төмс /кг/	1 000	800	80.0
	Лууван /кг/	1 000	1 500	150.0
	Манжин /кг/	1 200	2 000	166.7
	Байцаа /кг/	1200	1 300	108.3

	Сонгино /кг/	2 000	2 500	125.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	4 500	5 200	115.6
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	3 000	4 500	150.0
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 420	2040	143.7
	Бензин А - 92	1470	2070	140.8
	Дизелийн түлш	2 090	2690	128.7

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн Засаг даргын 2021 оны “Хөтөлбөр хэрэгжүүлэх, аян зохион байгуулах тухай” А/292 дугаар захирамжаар шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх, төрийн үйлчилгээний ил тод байдлыг нэмэгдүүлэх, хяналт хариуцлагыг дээшлүүлэх, удирдах ажилтны авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, захирах захирагдах ёсны зарчмыг хэрэгжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгуулах, ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор “Шударга Удирдагч, Шударга Төрийн албан хаагч” аяныг жил бүр аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлыг эхлүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны “ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТ хийх тухай” А/260 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг 24, 25-ны өдрүүдэд ажиллаж, 7 чиглэлийн хүрээнд хяналт, шалгалтын ажлыг явуулж, хяналт, шалгалтын ажлын хэсэг аймаг дахь хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан зөвлөмж чиглэл өгч ажилласан.

Авлигатай тэмцэх газрын 2021 оны “Авлигатай тэмцэх газрын ажлын хэсгийн орон нутагт ажиллах удирдамж”, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны “Авлигатай тэмцэх газрын орон нутагт ажиллах удирдамж”-ийн төлөвлөгөөний дагуу холбогдох нэгжүүдээс мэдээллийг гарган хянуулах ажлыг зохион байгуулсан. Тус удирдамжийн дагуу аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдлагууд болон телевиз, радио, сонины редакц, сайт, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтнууд, “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд орон нутагт ажил зохион байгуулсан, хамтран оролцсон байгууллагуудын удирдлагуудтай тус тус цахимаар уулзалт зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газрын орон нутагт ажиллах удирдамжийн дагуу асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй цахимаар уулзалт хийж, бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн.

Цагдаагийн газар: Аймгийн хэмжээнд 2021 оны эхний 11 сард 467 холбогдогчтой 2168.0 сая төгрөгийн хохиролтой 593 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 36 хэргээр буюу 6.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 56.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 5.0 хувиар өссөн байна.

Хэргийн төрлөөр нь ангилбал: Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 28 бүртгэгдэж 19 хэргээр буюу 3.1 дахин, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 201 бүртгэгдэж 35 хэргээр буюу 21.1 хувиар, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 71 бүртгэгдэж 5 хэргээр буюу 7.6 хувиар, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 37 бүртгэгдэж 11 хэргээр буюу 42.3 хувиар, Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдэж 2 хэргээр тус тус өссөн.

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 12 бүртгэгдэж 9 хэргээр буюу 42.9 хувиар, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 11 бүртгэгдэж 7

хэргээр буюу 38.9 хувиар, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 6 бүртгэгдэж 4 хэргээр буюу 40.0 хувиар, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 215 бүртгэгдэж 11 хэргээр буюу 4.9 хувиар, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 5 бүртгэгдэж 2 хэргээр буюу 28.6 хувиар, Эдийн засгийн гэмт хэрэг 2 бүртгэгдэж 1 хэргээр буюу 33.3 хувиар тус тус буурсан.

Улсын бүртгэлийн хэлтэс 10 дугаар сард иргэний бүртгэлийн талаар:

- Төрсний бүртгэл - 169 /эрэгтэй - 80, эмэгтэй - 89/
- Гэрлэлтийн бүртгэл - 41
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 7
- Үрчлэлт - 3
- Эцэг тогтоолт - 10
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 3
- Нас баралт - 94
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 376
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 127
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 25
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусч солиулсан - 224
- Гадаад паспорт олголт - 29
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн - 171

Төрийн өмчийн хорооны 2015 оны 617 дугаар тогтоолоор хувьчлагдсан Хөтөлийн “Цемент-шохой” ТӨХК-ий байнга хадгалах баримтыг хүлээн авахаар шийдвэрлэж, тус компанийн 1983-2015 оны 415 ХН-ийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэл, актын дагуу шилжүүлэн авсан.

Сайхан сумын ЗДТГ /Х-52/-ын 1976-2004 оны 232 ХН, Сант сумын ЗДТГ /Х-43/-ын 1953-2005 оны 130 ХН-д, аймгийн Хөдөө аж ахуйн үйлдвэр, туршилтын станц /Х-83/-ын 1973-1980 оны 42 ХН-д тус тус баримтын нягтлан шалгалтын хийж, тэдгээр хөмрөгүүдийн дансны ХН-ийн бүртгэлийг шинэчилсэн. Мөн Ерөө сумын ЗДТГ /Х-26/-ын хөмрөгийн 1948-2001 оны баримтад нягтлан шалгалт хийхээр сонгон авч тооллого хийж ажиллалаа.

Байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу архивын хуулбар 216, магадалгаа, тодорхойлолт 28 гаргасан бөгөөд онлайн хэлбэрээр 11 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Хөдөө аж ахуйн талаар: 2021 онд 131.0 мян.га талбайгаас 14.4 цн буюу 189.0 мян.тн улаанбуудай, 42.5 мян.га талбайгаас 32.5 мян.тн тосны ургамал, 2735.4 га талбайгаас 33.4 мян.тн хүнсний ногоо хураан авсан бөгөөд 2137 га талбайгаас 23.0 мян.тн төмс 99.2 хувьтай, 18 мянган га талбайгаас 30.5 мян.тн тэжээлийн ургамал 98.2 хувьтай нийт үр тарианы хураалт 99.9 хувьтай дууссан.

Аймгийн хэмжээнд 189.0 мян.тн улаанбуудай ургац хураан авснаас Хөдөө аж ахуйн дэмжих санд 29.8 мян.тн, өөрийн үрэнд 10.7 мян.тн, тэжээлд 6.2 мян.тн, спиртын үйлдвэрт 6.9 мян.тн, гурилын үйлдвэрт 93.7 мян.тн буюу нийт 153 мян.тн улаанбуудайн борлуулалт хийсэн.

Эрчимжсэн мал аж ахуйн эрхлэгч фермерүүд болон сүү бэлтгэлийн ажилтнууд зориулан сүүний урамшууллын талаар мэдээлэл олгох сургалтыг Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран Баруунбүрэн суманд зохион байгуулж, Мандал,

Баянгол, Сайхан, Сант сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдэд танхимаар, 13 суманд цахимаар мэдээлэл олгосон.

“Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран Мандал сумын “Сум хөгжүүлэх сангаас зээл” авсан 18 бизнес эрхлэгчдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, аймгийн хэмжээнд 2021 оны 11 дүгээр сарын байдлаар “Сум хөгжүүлэх сан”-д 126 иргэн, аж ахуйн нэгжийн 67 сая 300 мянган төгрөгийн эргэн төлөлт хийгдээд байна.

Засгийн газрын “2021-2022 оны мал өвөлжилт хаваржилтийн бэлтгэл ажлыг хангуулах тухай” 221 дүгээр тогтоолын дагуу аймгийн хэмжээнд хадлан тэжээл бэлтгэл ургац хураалтын үед хур бороо ихтэй, байснаас хадлан тэжээл бэлтгэлийн ажил цаг хугацааны хувьд удааширч, 17 сумын 56 багийн 8903 малчин болон мал бүхий өрхөд 1.8 сая толгой мал өвөлжихөөр зохион байгуулалтын арга хэмжээг авч, малчид зун, намрын улиралд хол, ойрын оторт гарч мал сүрэгтээ тарга хүч авахуулах ажлыг зохион байгуулснаар мал сүргийн 97 хувь нь дунд ба дундаас дээш тарга хүч авсан байна.

Улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурвас газарт 64.9 мянган мал бүхий 141 өрх өвөлжихөөр байна.

2021 онд 132.8 мян.тн байгалийн хадлан, 53.1 мян.тн хүчит тэжээл, 18.6 мян.тн эрдэс тэжээл бэлтгэхээс 155.6 мян.тн өвс, 3.5 мян.тн сүрэл, 11.6 мян.тн ногоон тэжээл, 18.9 мян.тн үйлдвэрийн тэжээл, 4.8 мян.тн дарш, 62.5 тн гар тэжээл, 9.5 мян.тн эрдэс тэжээл бэлтгэсэн нь малчин болон мал бүхий иргэдийн түвшинд бэлтгэх өвс, тэжээлийг 86.7 хувьтай бэлтгэсэн.

Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 100 тн ногоон тэжээл, 100 тн тэжээл бэлтгэхээс өвс, ногоон тэжээлийг бүрэн бүрдүүлж, 100 тн тэжээлийг “Алтан тариа” ХХК-тай гэрээ байгуулан цаг хүндэрсэн үед малчдад нийлүүлэхээр ажиллаж байна.

Сумдын нөөцөд 1700 тн өвс, 510 тн тэжээл бэлтгэхээс 1048 тн өвс, 510 тн тэжээл бэлтгэсэн нь 79,8 хувьтай, өөрийн болон гадны аймгийн иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас өөрийн хэрэгцээ болоод бизнесийн зориулалтаар 8.6 мян.тн өвс бэлтгэснээс 3,3 мян.тн-ыг борлуулж 11 дүгээр сарын байдлаар 5. мян.тн өвсний үлдэгдэлтэй байна.

Тариалангийн бүс нутаг болгон зарласантай холбогдуулан малын тоо толгойг бууруулах, мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр Орхон суманд махны чиглэлийн “Меринос” үүлдрийн хээлтүүлэгчийг хэрэгцээний эрлийзжүүлэгт ашиглаж “Меринос” үүлдрийн хонины түргэн өсөлттэй махлаг шинж чанар, монгол хонины бэлчээр ашиглах чадвар, тэсвэрт чанарыг шингээсэн нэгдүгээр үеийн эрлийз хургыг зун намар бэлчээрээр таргалуулан намар хурганы гулуузны жингийн кг тутамд 15.0 мянган төгрөгөөр борлуулах ажлыг эхлүүлж, тус сумын 22 малчин өрх хамрагдсан байна.

Хүйтний улирал эхэлж өвлийн идэш бэлтгэх үе болсонтой холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас махны өргөтгөсөн худалдаа зохион байгуулахаар шийдвэрлэж, 104 тн махыг нийлүүлсэн.

Мал эмнэлгийн үйлчилгээний талаар: Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын “Мал мах-2021” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, аймаг, сумын нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, тээвэрлэх, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, 3 суманд байнгын пост, бусад 14 суманд хөдөлгөөнт эргүүл пост гарган хяналт тавин ажиллаж байна.

Мал эмнэлгийн цахим системд 52 гэрчилгээгээр адуу 27, үхэр 215, хонь 856, ямаа 1, нийт 857 толгой мал сум дотроо үржлийн зориулалтаар шилжилт хөдөлгөөн,

Хушаат сумын 16 дээжид ийлдэс судлалын шинжилгээг хийж халдварлалтгүй болохыг тогтоож хариу, 3687 гэрчилгээгээр адуу 171, үхэр 1591, хонь 3643, ямаа 2581, гахай 5 толгой буюу нийт 7749 толгой мал, амьтан, 672730 кг мах, махан бүтээгдэхүүн, 451824 кг сүү, сүүн бүтээгдэхүүн, 1820 ш арьс шир, түүхий эд буюу нийт 17052 кг, ширхэг бүтээгдэхүүний мал эмнэлгийн гэрчилгээ олгож, цахим мэдээллийн сан үүссэн.

Орхонтуул 2, Шаамар 6, Сүхбаатар 10, Алтанбулаг 2, Баруунбүрэн 12, Баянгол 2, Ерөө 3, Жавхлант 8, Зүүнбүрэн 2, Мандал 10, Цагааннуур 5, нийт 62 удаагийн мал, амьтны халдваргүй өвчний дуудлага мэдээлэл ирж, сумдын МЭТ, МЭҮН-ийн эмч нар түргэн шуурхай цаг алдалгүй үйлчилгээ үзүүлж эмчилгээ хийж мэргэжил арга зүйн заавар зөвөлгөөг малчид, мал бүхий иргэд өгч ажиллалаа.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах махан бүтээгдэхүүний 13900 кг үхрийн махны 123 дээж, 2853 кг хонины махны 198 дээж, 1719 кг ямааны 132 дээж, сүү, сүүн бүтээгдэхүүний 320 л сүүний 3 дээжид ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчны талаар: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний нээлтээр 1 га, “Ойн салбарын 100 жил”-ийн ойд зориулан Ойн алба, ойн ангиудын санаачлагаар 1 га, гадаадын хөрөнгө оруулалтаар /Япон улсын төрийн бус байгууллага/ 11 га, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар цөлжилт, элсний нүүлтээс хамгаалсан ойн зурвас 20 га нийт 1497 га талбайд ойжуулалт, ойн зурвасын ажлыг хийсэн.

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд хавар, намар 17 сумын 326 аж ахуйн нэгж, байгууллага, 6172 иргэн, 56240 ширхэг мод, бут, сөөг тарьж ургуулан хамгаалалтад авсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 342 тоот захирамжийн дагуу Ерөө сумын Баянголын төмрийн хүдрийн орд “Болдтөмөр Ерөө гол” ХХК, Тэсрэх бодисын үйлдвэр “Монтай-Эрдэнэ” ХХК, Толгойтын алтны шороон орд “Ди Зэт анд Ай” ХХК, Хүнгүйч Зүр Хүзүүгийн алтны шороон орд “Капитал авто сервис” ХХК, Өлөнтийн алтны шороон орд “Монлидтрейд” ХХК, Уулзварын алтны шороон орд “Жинжий майнинг” ХХК, Баянгол сумын Их Даширын хөндийн алтны үндсэн орд “Бороогоулд” ХХК, Цагаанчулуутын алтны үндсэн орд “Сонортрейд” ХХК, Цагаан чулуутын алтны үндсэн орд “Хонгорын орд” ХХК, Нарангийн алтны шороон орд “Пентатерра” ХХК, Түшиг сумын Баруун хужрын хөндийн алтны шороон орд “Шар нарст” ХХК, Сайхан сумын Хөтөлийн цементийн үйлдвэр “Цемент Шохой” ХК, Хүдэр сумын Төмөртэйн төмрийн хүдрийн орд “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХК зэрэг 13 аж ахуй нэгж, байгуулагуудын 2021 онд байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлантай танилцаж, дүгнэлт гаргаж ажиллалаа.

Аймгийн Аялал жуулчлалын маршрут, амралтын газрын байршлыг харуулсан гар утасны аппликейшинг “Аялал жуулчлалын төв” ААТӨҮҮГ-аар гүйцэтгүүлж, ажлын явц 90 гаруй хувьтай байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20 дугаар тогтоол “2022 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай” болон Сэлэнгэ аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврыг баталгаажуулан хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/341 тоот захирамжаар Сүхбаатар сумын 8 иргэнд 9279 м2 буюу 25.470.0 төгрөгийн үнэ бүхий газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүйгээр өмчлүүлж, аймгийн Засаг даргын 9 удаагийн

захирамжаар 16 иргэний 6954 м2 газрын эзэмших эрхийг 14 иргэн 2 аж ахуйн нэгжид шилжүүлж, 2 иргэний 2828 м2 газрын эзэмших эрхийн зориулалтыг өөрчилж, 2 иргэний 73 м2 газрын эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгаж, шинээр 2 иргэнд 278 м2 газрыг гэр орон сууцны зориулалтаар тус тус эзэмшүүлэх шийдвэрийг гаргуулсан.

Сүхбаатар, Алтанбулаг, Мандал, Шаамар сумдын газар эзэмших эрхийн дуудлага худалдааг зохион байгуулж, дуудлага худалдааны зарыг газрын цахим бирж, “Зууны мэдээ” сонинд байршуулж Сүхбаатар, Алтанбулаг, Мандал сумдын дуудлага худалдааг зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/276 тоот захирамжийн дагуу Алтанбулаг, Мандал, Цагааннуур сумдын Ойн ангитай хамтран ойн санг гэрээгээр эзэмшигч “Өргөн Сэлэнгэ” ХХК, Ойн хүрэм ХХК-ий өөрийн хөрөнгөөр ойжуулсан болон, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар ойжуулсан нийт 320 га талбайд хяналтын хэмжилт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

17 сум, 6 тосгоны 1063 барилга байгууламжийн мэдээллийг цаасан байдлаар болон 4 талт фото зургаар бүрдүүлэн хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэж, 5 ажилд барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад хүлээн авах зөвшөөрлийг цахимаар олгосон.

Ерөө сумын 2-р баг, “Хужрын Хаяа” хэсгийн айл өрхийн гадна цахилгаан хангамж, Сайхан сумын Гавшгай 2-р баг, Залуучуудын хөгжлийн ордны ажлын зураг, Алтанбулаг сум Алтанбулаг чөлөөт бүс “Нэг бүс нэг зорилго чөлөөт бүс” ХХК –ий үйлчилгээний барилга, Түшиг сумын Улаан Овоотод байрлах “Техно Перспектив” ХХК –ий нүүрсний уурхайн гадна цахилгаан хангамжийн 10кВ–ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 10/04 кВ –ын 800 кВА чадалтай дэд станцын ажлын зургийн хянасан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлэн ажиллах 5 ажлын барилга байгууламжид явцын хяналт шалгалтыг хийж холбогдох үүрэг даалгавар, заавар зөвлөмжийг өгч ажилласан.

9 барилга байгууламжид улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээлцүүлж, 2 тодруулах хуудас зөвшилцсөн.

Тав. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2021 оны А/263 тоот тушаал, сумын Засаг даргын 2021 оны “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/218 тоот захирамжийн дагуу дархлаажуулалтын ажлыг зохион байгуулж, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад нийт 21200 мал, амьтан хамруулахаас 9572 мал, амьтан хамруулаад байна

Тус сумын харъяа “Тэргүүн тэлмэн” ХХК нь Алтанбулаг сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Гүннуур” гэх газарт хувийн хөрөнгө оруулалтаар махны чиглэлийн эрчимжсэн үхрийн аж ахуй байгуулах ажлыг хийж 60 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус компани нь үхрийн эрчимжсэн аж ахуйг байгуулах ажлын хүрээнд 2021 онд 74 га талбайд тэжээлийн ургамал тариалж, 150 тн малын тэжээл, 300 тн дарш, 10 тн овьёосны үр бэлтгэсэн. Махны чиглэлийн “Сэлэнгэ” үүлдрийн 100 үхэр, хээлтүүлэгч малаар “Герефорд” үүлдрийн 5 бухийг худалдан авч суурин маллагааны аргаар өсгөн үржүүлж байна.

Тус суманд “Хүчү агро” ХХК мах бэлтгэлийн үйлдвэрлэлийг үйл ажиллагааг 2021 оны 09 дүгээр сараас эхлэн явуулж, 16 нэр төрлийн үхрийн стейкны алаг махыг бэлтгэн худалдаанд гаргаж байна.

Ойн сан гэрээгээр эзэмшигч 13 аж ахуй нэгж, нөхөрлөлүүдэд “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах нь” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Эхний 11 сарын байдлаар сумын хэмжээнд өссөн дүнгээр нийт 396 тохиолдол бүртгэгдсэнээс 370 иргэн эмчлэгдсэн 20 иргэн гэрээр эмчлэгдэж, 6 иргэн нас барсан.

11 дүгээр сард 65 тохиолдол бүртгэгдэж, үүнээс аймгийн Нэгдсэн эмнэлэгт 10 иргэнийг хэвтэн эмчлүүлж, гэрийн эмчилгээнд 55 иргэнийг хамруулж эмийн багц тарааж хяналтад авч ажилласан.

Тус сард түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд 179 иргэн, PCR шинжилгээнд 5 иргэнийг хамруулж, коронавируст халдвар илэрсэн тохиолдлуудын ойрын болон дам хавьтлыг тодорхойлох тандалт судалгааны “Хариу арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажиллагаа – зохицуулах” багийн 12 гишүүн хариуцан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийг эрчимжүүлэх тухай” А/15 тоот захирамжийн дагуу төр, төсвийн 7 байгууллага, худалдаа үйлчилгээний 50 газрын нийт 271,200 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэлээ.

11 дүгээр сард нийт 325 вакцин хийгдсэн бөгөөд үүнээс 0-15 насны хүүхдийн дархлаажуулалтад товллын дагуу 39 хүүхэд, /Ковид-19/ вирусын эсрэг 3-р тунд 180, улирлын томууны вакцинд 106 иргэн тус тус хамрагдсан байна.

Баруунбүрэн сум:

Орхон бүсийн сум дундын Ойн ангиас сумын иргэдийн болон Орхон, Орхонтуул, Сайхан сум, Сайхан сумын Номгон тосгоны иргэдийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хүрээнд сумаас түлшний мод бэлтгэх эрхийн бичгийг 200 гаруй иргэнд, Орхон болон Сайхан сум руу нийт 60 гаруй гарал үүслийн гэрчилгээг бичиж ажилласан. Мөн “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх” ажлын хүрээнд иргэдэд цахимаар болон малчин айл өрхүүдэд гарын авлага 100 гаруй ширхгийг бэлтгэн тараан өгч ажиллалаа.

2021 оны 11-р сарын 16-ны өдөр тус сумын Бургалтай 2 дугаар багийн нутагт 1 малчин өрхийн үхэрт мал, амьтны гоц халдварт Шүлхий /А01/ өвчний шинж тэмдэг илэрсэн тухай дуудлага хүлээн авч холбогдох арга хэмжээг авахад шинжилгээний дүнгээр “Шүлхий /А01/ мөн болох нь батлагдсан. Сумын Онцгой комисс шуурхай хуралдаж, сумын Засаг даргын 2021 оны “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” А/170 тоот захирамжийг гаргасан. Захирамжийн дагуу арга хэмжээ авч 1 дүгээр ээлжид 38 өрхийн 244 үхэр, 576 богт вакцинжуулалтын ажлыг хийж, 2 дугаар ээлжид 255 өрхийн 70663 толгой малыг вакцинжуулахаар төлөвлөн ажиллаж байна.

11 дүгээр сарын байдлаар сумын хэмжээнд 34 малчин өрхийн 279 үхэр, 52 хонь, 2 ямаа өвчилсөн дуудлага ирснийг тусгаарлан ажиллаж байна.

Хөдөлмөр, халамжийн газраас зохион байгуулж буй “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-д тус сумаас оролцогч хүнсний эрхийн бичигт хамрагддаг өрхийн 1 гишүүн “Оролцоо төслийн сургалт”-д 14 хоног хамрагдаж, дадлагажуулах арга хэмжээний гурвалсан гэрээ байгуулсны үндсэн дээр сумын 1-р цэцэрлэгт дадлага хийж байна.

Баянгол сум:

Сумын Засаг даргын 2020 оны “Шуурхай штаб байгуулж ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А\254 дүгээр захирамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын байранд шуурхай штабыг байрлуулан 24 цагийн хариуцлагатай жижүүрийг томилж,

үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг аймгийн онцгой комисс болон холбогдох байгууллагад 70369123 дугаарын утсаар болон цахимаар буюу Bayangolshuurhaishtab@gmail.com хаягаар тогтмол хүргүүлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 239, 254 дүгээр тушаалаар “Коронавируст халдварын батлагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх өвчтөнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх түр журам”, “Сэжигтэй болон эмнэл зүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн өвчтөнийг гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах түр заавар”-ын хүрээнд 68 иргэн гэрийн эмчилгээнд хамрагдаж байна.

УИХ-ын гишүүн Ч.Ундрам ажлын айлчлал хийж, цэвэрлэх байгууламж, бохирын станц, ЕБС-ийн дотуур байр, хүүхдийн хоолны газрын их засварын ажилд шаардлагатай төсвийг бусад гишүүдтэй хамтран ирэх оны төсөвт тусгаж шийдвэрлэх талаар ярилцаж тус сумын Эрүүл мэндийн төвд 3 ш компьютер, 2 хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч гардуулан өглөө.

Сумын Засаг даргын 2021 оны “Аж ахуй нэгж байгууллагын улсын тооллого явуулах тухай” А/178 тоот захирамжийн дагуу 222 аж ахуй нэгж байгууллага бүртгэхээс 188 аж ахуй нэгж байгууллага, 74 хувиараа хөдөлмөр эрхлэгчийг бүртгэж 85 хувийн явцтай байна.

Иргэний Нийгмийн 26 байгууллагын санаачилсан, Японы ядуурлыг бууруулах сан, Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “КОВИД-19 цар тахлын нөлөөг олон нийтийн оролцоотой бууруулах нь” төслийн компанит ажил албан ёсоор нээлтээ хийлээ.

Баянгол сумын ИТХ-ын 2021 оны 29 дүгээр тогтоолын дагуу малчин болон мал бүхий иргэдэд малын тоо толгой албан татварыг 2021 оны 12-р сарын 01-нээс өмнө төлөхийг мэдэгдэж, дахин давтагдахгүй нэхэмжлэхийн дугаарыг өрх бүрд олгож малын тоо толгойн албан татвар 929 өрхийн 336.252.0 татвар хураахаас 155 өрхийн 31.338.368 төгрөг буюу сумын хэмжээнд 9.3 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

Аймгийн хэмжээнд мал, амьтны гоц халдварт А01 буюу шүлхий өвчний дэгдэлт буурахгүй, хүйтний улиралд хурдан тархах магадлалтай байгаа тул аюулгүй байдлыг хангах, үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн МЭГ-аас 94400 тун вакцин ирснийг 20048 үхэр, 54184 бог, 60 гахай нийт 74292 толгой малыг бүрэн хамруулаад байна.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “ЖҮДО бөхийн өсвөр үеийн 2020 оны Улсын аварга шалгаруулах тэмцээн” 50 багийн 1000 гаруй өсвөрийн тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс Н.Батболд дасгалжуулагчтай 44 кг-ын жинд сурагч Г.Мөнхжаргал мөнгөн медаль, Мөн Парисын их дуулга буюу Бага дэлхийн аваргын тэмцээнээс 21 настай залуу тамирчин Гэрэлтуяагийн Болор-очир хүрэл медаль хүртэж амжилтаа ахиуллаа.

Ерөө сум:

“Монгол улсын иргэнд Газар өмчлүүлэх тухай” хуулийн дагуу газар өмчлөх хүсэлт гаргасан 14 иргэнд сумын Засаг даргын захирамжаар нийт 3.2 га газар, төр, төсвийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд 3 нэгж талбарын 1.68 га газар, төмс хүнсний ногооны зориулалтаар 1 нэгж талбарын 2 га газрыг тус тус шийдвэрлээд байна.

Засгийн газрын 2021 оны “Аж ахуйн нэгжийн улсын тооллого явуулах тухай” 315 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/316, сумын Засаг даргын 2021 оны А/237 тоот “Аж ахуйн нэгж байгууллагын улсын тооллого зохион байгуулах тухай” захирамжуудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын хэмжээнд 405 аж ахуй нэгж,

36 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг хамруулан гүйцэтгэл 93 хувьтай явагдаж байна.

Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Бугант тосгоны нийтийн орон сууцнуудын дээвэр засварлах” 132,0 сая төгрөгийн өртөгтэй ажилд “Уран төмөр хэлхээ” ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.

Сумын хэмжээнд “Золбин нохой устгал”-ын арга хэмжээг зохион байгуулж 277 золбин нохойг устгалд оруулсан байна.

11 дүгээр сард Коронавируст /Ковид-19/ цар тахлын 75 тохиолдол батлагдаж 14 иргэн эмчлэгдэж, 39 иргэн гэрийн ажиглалтад, ерөнхий боловсролын сургуулийн 23 хүүхэд гэрийн тусгаарлалтад байна. Эрүүл мэндийн төвийн Ковидын тасагт 22 иргэн хэвтэн эмчлүүлж байна.

Сумын Засаг даргын захирамжаар “Сонгдо” эмнэлгийн их эмч Б.Болдсайхан эмчийн “Зүрх мартаггүй төсөлд” хамрагдсан 4 хүүхэд 1 иргэний 5,0 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон байна.

Залуучуудын 100 жилийн ойн хүрээнд “Сайн үйлсийн аян”-ыг өрнүүлэн Тавин 1 дүгээр багийн 1 өрхөд 200.0 мянган төгрөгийн мөнгөн тусламж, 2 чиргүүл түлээний мод хандивласан байна.

Сумын Засаг даргын 2021 оны “Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай” А/261 тоот захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 9 малчин өрхийн 6660 м2 хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлт, хил залгаа сумдаас амьд мал оруулахыг тодорхойгүй хугацаагаар хязгаарлах, эргүүл жижүүр ажиллуулах төлөвлөгөөг боловсруулан нийтдээ 5.399.990 төгрөгийг зарцуулаад байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 1,2 дугаар багийн нийт 278 иргэнд 1176 м3 түлээний эрхийн бичгийг олгоод байна.

Жавхлант сум:

Сумын Засаг даргын батлагдсан удирдамжийн дагуу төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд өвөлжилтийн бэлтгэл ажил хангах аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгаврын биелэлтийг газар дээр нь шалган танилцаж заавар зөвлөмж өгч ажилласан.

Өвөл цагийн соёл, хүмүүжлийн ажлын нээлтийн арга хэмжээг “Архигүй, хүчирхийлэлгүй, эрүүл, аюулгүй орчин” сэдвийн дор эхлүүлж тус ажлын хүрээнд төрийн байгууллагуудын дунд АСТ зохион байгууллаа.

“Төрийн албан хаагчийн манлайлал-5” болзолт уралдааныг зохион байгуулж төрийн албан хаагчийн манлайллыг сайжруулан ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор “ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛ”-ын үйл ажиллагааг зохион байгуулж 16 нас хүрч иргэний үнэмлэх авч байгаа 5 иргэн андгай өргөж, “ТУСГААР ТОГТНОЛ” сэдвээр сумын Засаг даргын орлогч С.Нямсүрэн илтгэл тавилаа.

Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын Бумбат 1-р багийн нутагт 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр мал, амьтны гоц халдварт /А01/ шүлхий өвчний шинж тэмдэг илэрч мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр баталгаажсан тул сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн “Хорио цээрийн дэглэм түр тогтоох тухай” А/137 тоот захирамж гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус сумын Бумбат 1 дүгээр багт шүлхий өвчний ил шинж тэмдэг илэрсэн тул холбогдох айл өрхийн малыг урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулахад 5,398.1 мянган төгрөгийн зардал гараад байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 51.8 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдэх зам засварын ажлын 115 м асфальтан замын ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн.

Аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Моностой, Бумбат багуудын малын худгийн 91.0 сая төгрөгийн тендерт “Сүлд хамба” ХХК шалгарч ажлыг гүйцэтгэл 50 хувьтай явагдаж байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй гэрэлтүүлэг нэмэгдүүлэх тендерийн 51.0 сая төгрөгийн ажлыг “Хайтек” ХХК 100 хувь хийж гүйцэтгэсэн.

Сумын Эрүүл мэндийн төвийн дэргэд аймгийн Онцгой комиссын шийдвэрээр ковидын тасгийг 10 дугаар сарын 21-ний өдөр нээн ажиллуулсан. Ковидын тасагт 69 иргэн хэвтэн эмчлүүлж гэрийн хяналтад шилжиж, 5 иргэн хэвтэн эмчлүүлж, гэрийн эмчилгээнд 9 иргэн хамрагдсан байна.

ЕБС-ийн сурагчдын дунд бага боловсролын багш нар “Бид яагаад суралцах хэрэгтэй вэ?”, дунд ангийн анги удирдсан багш нар “Миний боловсрол 21-р зуунд”, ахлах ангийн анги удирдсан багш нар “Миний ирээдүйн мэргэжил” сэдвүүдээр сургалт зохион байгуулж 250 сурагч хамрагдсан.

Сумын Засаг даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/136 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 11 хоногийн туршид мал, гахайтай өрхийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Мал эмнэлгийн газраас ирүүлсэн 1-р ээлжид ирсэн 12500 тун вакциныг тарих ажлыг мал эмнэлгийн нэгжийн 2 эмч, 6 төрийн албан хаагчид дайчлагдан ажиллаж нийт 70 өрхийн 3495 үхэр, 11675 хонь, ямаа 8647, 23 гахай 23838 толгой мал, амьтныг вакцинжуулалтад хамруулаад байна.

Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан сумын Гамшгаас хамгаалах штаб, явуулын хөдөлгөөнт эргүүл шалгалт хийх хяналтын пост 1 нийт 24 төрийн албан хаагч, иргэд ажиллаж байна.

2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг сумын хэмжээнд 90 хувь хангаад байна. 11 дүгээр сарын байдлаар 460 малчин, мал бүхий өрхийн 140782 мян.тол мал өвөлжиж байна. Малчин, мал бүхий 250 өрхтэй хадлангийн талбайн ашиглалтын гэрээ хийж нийт 3300 га-д гэрээ байгуулан 6.2 сая төгрөгийг сумын аюулгүйн санд төвлөрүүлж, малчдын бэлтгэсэн өвс 7900 тн, тэжээл 32 тн, хужир 8,5 тн, сумын аюулгүйн нөөцөд бэлтгэсэн өвс 10 тн, малчдын худалдан борлуулахаар бэлтгэсэн өвс 95 тн байна.

Сумын Засаг даргын А/63 тоот захирамжийн дагуу Малд үзлэг ангилалт, ээмэгжүүлэлт хийх ажлыг зохион байгуулж бог малын ангилалтад нийт 2565 мал үүнээс 420 бог ээмэгжүүлсэн, бод малын ангилалт нийт 545 мал үүнээс 180 бод ээмэгжүүлсэн.

Өвчлөл бүртгэгдсэн өдрөөс эхлэн нийт 22 өрхийн 263 үхэр, 42 хонь, 4 ямаа нийт 309 толгой малд гоц халдварт /А01/ өвчний шинж тэмдэг илэрч, ээмэгжүүлэн бүртгэлжүүлэн ажиллалаа.

Аймгийн ИТХ-аас баталсан 2020 оны 08 тоот тогтоолоор баталсан хэрэглээний болон түлээний мод бэлтгэх хуваарийн дагуу Хүдэр сумын Засаг дарга болон Хүдэр сумын ойн ангитай хэрэглээний мод, түлээний мод бэлтгэх гэрээг тус сумын Засаг дарга, байгаль хамгаалагч нар хийсний дагуу Хүдэр Очир ХХК-аас тус сумын 16 өрх нь нийт 64 м3 түлээний зах банз, уурган захыг авч өвөлжилтийн бэлтгэлээ ханган ажилласан.

Ургац хураалтын эцсийн дүн улаан буудай 8328 га-аас 8800 тн, овъёос 60 га-аас 90 тн, тэжээлийн ургамал 290 га-аас 320 тн, тосны ургамал 2580 га-аас 735 тн, төмс, хүнсний ногоо 141 га-аас 1940 тн ургац тус тус хураан аваад байна.

2022 оны нөөцөлсөн үр 460 тн улаан буудайн хураан авсан ургацаас 6870 тн гурилын үйлдвэрт, хөдөө аж ахуйг дэмжих санд 855 тн, малын тэжээлд 1370 тн, үтрэмд борлогдоогүй улаан буудай 100 тн, нөөцөлсөн төмс, хүнсний ногоо 650 тн байна.

Зүүнбүрэн сум:

Хамтарсан багаас 10 хоногийн хугацаанд “Архигүй эрүүл орчин” аяныг зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Би архигүй орчинг хүсч байна”, “Архигүй орчин гэр бүлийн аз жаргал” сэдэвт гар зургийн уралдааныг тус тус зохион байгуулж 40 хүүхэд оролцсноос 3 насны ангиллаар 1-3 дугаар байрыг шалгаруулж өргөмжлөл, гарын бэлгээр шагнаж урамшуулаа.

Хамтарсан багийн хурлыг 2 удаа зохион байгуулж хурлаар хүүхдийн мөнгөн тэтгэмж, үрчлэлттэй холбоотой 2 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, эрсдэлт нөхцөлд байгаа нэг өрхийн 1 хүүхдэд хамтарсан багийн төсвөөс 20800, гишүүдийн хандив 70000 төгрөг нийт 90800 төгрөгийн хичээлийн хэрэгсэл, эд материалын тусламж дэмжлэг үзүүллээ.

11 дүгээр сарын 19-ний өдөр Мангирт багийн 1 өрхийн 1 үхэрт шүлхий өвчин илэрч өвчилсөн малаас ийлдэс, эдийн шингэний дээж авч мал эмнэлгийн төв лабораторид хүргэж, голомтын болон сэжигтэй бүсийн 11 айл өрхийн малын хашаа, өвчтэй малын бэлчээрийн 2330 м² талбайд ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийлээ.

11 дүгээр сарын байдлаар Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад эрүүл бүсийн 1278 толгой мал, амьтан хамрууллаа.

Сумын Онцгой комиссын орлогч даргын баталсан хуваарийн дагуу голомтын болон сэжигтэй бүсэд Засаг даргын Тамгын газрын албан хаагчид 48 цагаар жижүүрлэн ажиллаж байна.

/Ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх дархлаа сэргээх III тунгийн 402 хүн тун вакцин хүлээн авснаас I тунд 13, II дугаар тунд 11, III тунд 348 иргэнийг тус тус хамрууллаа.

“Мэргэжил сонголт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” аяны хүрээнд зохион байгуулсан “Миний мэргэжил-Миний ирээдүй”, “Мэргэжлээ сонгох арга”, “Хорт зуршил-цахим хэрэглээ” сэдэвт сургалтуудад ерөнхий боловсролын сургуулийн X-XII ангийн 18 суралцагч хамрагдлаа.

Хүүхдийг гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх “Эцэг эхийн эргүүл” арга хэмжээг сургуулийн орчинд зохион байгуулж 35 эцэг, эх хамрагдлаа.

Мангирт 3 дугаар багийн нутаг дэвсгэрээс олдсон археологийн олдвор вааран савыг /хагархай 116 ширхэг деталлыг/ Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн археологийн олдворын эрдэмтдийн ажлын хэсэгт хүлээлгэн өгч судалгаанд хамрууллаа.

2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд Түшиг сумын гурван ховил гэх газраас 476 м³ түлээний модыг 157 өрхөд олголоо.

Давуу эрхээр 4 иргэнд 5 га газрыг төмс, хүнсний ногооны зориулалтаар сумын Засаг даргын “Давуу эрхээр газар эзэмшүүлэх тухай” А/129 тоот захирамжаар, дуудлага худалдааны ялагч 1 иргэнд банк, санхүүгийн зориулалтаар 0,04 га газрыг сумын Засаг даргын “Газар эзэмшүүлэх тухай” А/131 тоот захирамжаар тус тус эзэмшүүллээ.

Мандал сум:

Мандал сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр бүрэн дунд сургуулийн ахмад багш Балсангийн Уунай “Монгол улсын гавьяат багш” цол тэмдгээр шагнагдлаа.

“Хүүхдийг эх оронч үзлээр төлөвшүүлэх, түүх, соёл, зан заншлаараа бахархах, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл хандлага тогтоох” зорилго бүхий “Иргэний андгай өргөх ёслол”-ыг Бүгд найрамдах Улс тунхагласны түүхэн ойн баярыг тохиолдуулан зохион байгууллаа.

“АШУҮИС”-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Урьдчилан сэргийлэх тэнхимтэй хамтран “Өсвөр үеийнхний эрүүл мэнд-Мэргэжилтний зөвлөгөө” сэдэвт сургалтыг зохион байгуулан ерөнхий боловсролын 11 дүгээр анги болон политехникийн коллежийн нийт 58 суралцагчийг хамрууллаа.

Даатгуулагч /иргэн/-д хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийх аяны хүрээнд улсын магадлангийн комисс Мандал суманд ажиллан нийт 232 иргэний хөдөлмөр алдалтын хувь хэмжээ тогтоож, хугацаа сунгах ажлыг зохион байгууллаа.

“Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн долдугаар арга хэмжээний хүрээнд сумын төвийн төвийн авто болон явган хүний замыг цэвэрлэх ажлыг хийж 3 хоногийн хугацаатай хийж нийт 27 түр ажлын байр бий болсон бөгөөд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүдийг ажлын байраар хангаж ажиллалаа.

2021-2022 оны мал өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах зорилгоор сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 30 тн тэжээл нөөцлөхөөр бэлтгэл хангаад байна.

Сумын хэмжээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 53 аж ахуйн нэгж байгууллага, 1051 өрх үр тариа 6003,7 га талбайгаас 7235 тн, тэжээлийн ургамал 1688,42 га талбайгаас 9700,5 тн, техникийн ургамал 497 га талбайгаас 172 тн, төмс 500 га талбайгаас 4500 тн, хүнсний ногоо 681,67 га талбайгаас 10900,12 тн ургац тус тус хураан авлаа.

Сумын Засаг даргын Тамгын газраас АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилттэй, “Хөгжлийн Шийдэл” ТББ-ын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөртэй хамтран Жижиг Дунд Бизнесүүдийн санхүүгийн боловсрол, компанийн засаглалыг сайжруулах зорилтын хүрээнд “Зээлийн боловсрол”, “Гэр бүлийн бизнесийн засаглалын тухай ойлголт” сэдэвт сургалтыг Жижиг дунд бизнес эрхлэгч нарт зохион байгууллаа.

“Мандалд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 34 иргэн, ААНБ 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцлоо.

Сумын Засаг даргын Тамгын газар ШУТИС, УБТЗ-ын “Мод боловсруулах үйлдвэр”-тэй хамтран Профессор Ганбаатар, багш Доктор Сүрэнжав нарыг урьж “Үйлдвэрийн аюулгүй ажиллагаа” болон “Мод бэлтгэлийг технологийн дагуу бэлтгэх” сэдвүүдээр Мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулдаг ойн мэргэжлийн байгууллагуудад “Хөдөлмөр хамгаалал ба хариуцлага” сэдэвт 1 өдрийн онол болон практикийн сургалтыг зохион байгуулж нийт 28 ойн мэргэжлийн байгууллагуудын 31 ажилтныг хамрууллаа.

Сумын хэмжээнд өвөлжилтийн түлшний бэлтгэлийг хангахаар аж ахуй нэгж байгууллагуудад олгогдсон түлээний эрхийн бичгээс 11 ойн мэргэжлийн байгууллага 11 дүгээр сарын байдлаар 824,4 м3 түлшний модыг доод агуулахад татан төвлөрүүлээд байна. Сумын төвийн 7 багуудаас 1,2 дугаар ээлжийн хөнгөлөлттэй үнээр түлээнд хамрагдах 244 өрхийн судалгааг авч аж ахуй нэгж байгууллагууд хуваарилсан ба 92 айл өрхөд хөнгөлөлттэй үнээр түлээгээ олголоо. Мөн 6 иргэнд үнэгүй түлээ олгосон.

Тарни 8-р багийн цахилгаан эрчим хүчний асуудалтай 30 айл өрхүүдэд 160 кВа дэд станц 0.4кВ-ын 0.5 км шугам барьж ашиглалтад орууллаа.

Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр хүртэлх Улаанбаатар чиглэлийн 45,2 км, Түнхэл тосгон доторх 4 км хатуу хучилттай авто замын зураг төслийг “Ар Си Эс Си” ХХК боловсруулж, магадлалын дүгнэлтийн хамт хүлээлгэн өглөө. Тус замын трассын дагуу нийт 3 гүүр гарах бөгөөд авто зам болон гүүрийн барилгын угсралтын ажлын нийт дүн 52.4 тэрбум төгрөг байна.

Тус суманд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Ньюпроцесс” ХХК-ий хэрэгжүүлсэн Хэрх тосгоны 0,55 км асфальтан хучилттай, Түнхэл тосгоны 1,34 кмбетон хучилттай автозамын ажил гэрээний дагуу бүрэн дуусч улсын комисст хүлээлгэн өглөө.

Сумын хэмжээнд 48 барилгын гадна фасадыг засварлах, 23 барилгын дээврийг шинэчлэх ажлын зурагт төсвийг боловсрууллаа.

Монгол Улсын Засгийн Газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн Газар хооронд байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжиж буй “Дэд бүтцийн хөгжил-Баянзүрх, Дархан, Сэлэнгэ” гэр хорооллын гудамж, нийтийн зам, талбайн гэрэлтүүлгийн төслийн хүрээнд тус суманд төв замын дагуух 400 ширхэг гэрэлтүүлэг суурилуулж ашиглалтад авлаа.

Сумын Засаг даргын 2021 оны өдрийн А/122 тоот захирамжаар хүүхдийн тоглоомын талбайн зориулалтаар олгогдсон 7687 м2 газарт Баянсуудалын 3-р багийн нутаг дэвсгэрт Хорих 413-р ангийн баруун талд байрлах АТП-156-аас АТП-171, АТП-173, АТП-149, АТП-164-ыг тус тус тэжээдэг 6 кВ-ын агаарын шугам нь трассын дагуу давхцаад байсан тул ДСЦТС ХК-тай хамтран тус шугамын трассыг өөрчилж хуучин модон тулгууруудыг бетон тулгуураар шинэчилж, хамгаалалтын зурваст айл өрхийн хашаа дайрч байсан зөрчлүүдийг арилгалаа.

Орхон сум:

Тус сумын Бэлэндалай 2-р багийн нутаг дэвсгэр “Агьтын хошуу” гэх газарт 2021 оны 11 дугаар сарын 10-ны өдөр мал, амьтны гоц халдварт шүлхий /А01/ өвчний шинж тэмдэг илэрч, шинжилгээний дүгнэлтээр баталгаажсан.

Сумын Засаг даргын 2021 оны “Хязгаарлалтын дэглэм түр тогтоох тухай” захирамж дагуу Бэлэндалай багт хэсэгчлэн хязгаарлалтын дэглэм тогтоосон. Захирамжийн хүрээнд Гамшгаас хамгаалах штаб, Мэргэжлийн баг хамтран шүлхий /А01/ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулж байна.

Аймгийн нөөцөөс 36100 тун вакциныг сумын Онцгой комисст татан төвлөрүүлж, газар нутгийн байршлаар нь голомтын, хамгаалалтын, эрүүл гэсэн бүсчлэл тогтоон вакцинжуулалтыг хийгээд байна. Одоогийн байдлаар нийт 177 өрхийн 7877 үхэр, 28399 бог, 66 гахай нийт 36342 толгой мал, амьтныг хамруулаад байна.

Голомтын бүсэд өнөөдрийн байдлаар шүлхий /А01/ өвчний шинж тэмдэг илэрсэн гэх 30 өрхийн 182 толгой мал байна. Ариутгал халдваргүйжүүлэлтийг 120 малын хашаа хорооны 53090 м2 талбайд хийгээд байна.

Үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор аймгийн Мал эмнэлгийн газраас 1 мэргэжилтэн, Мандал, Ерөө, Сант, Баруунбүрэн, Алтанбулаг зэрэг 5 сумын малын эмч нар дайчлагдан ажиллалаа. Сумын Засаг даргын 2021 оны А/112 тоот захирамжаар томилогдсон малын эмч, бүртгэгч, мал баригчийн бүрэлдэхүүнтэй 4 ажлын хэсэг дархлаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Цаг үеийн болоод коронавирусын халдварын талаарх зөвлөмж, анхааруулга, сэрэмжлүүлгийг цахим орчинд байршуулах ажлыг зохион байгуулж тус хугацаанд “Сэлэнгэ Орхон сум ЗДТГ”, “Сэлэнгэ аймгийн Орхон сум” “Нарт Орхоны хүүхдүүд” зэрэг фэйсбүүк группүүдэд 17 удаагийн мэдээ мэдээллийг хүргэж 162 хүний хандалтыг авсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 08 тоот тогтоолын дагуу Баруунбүрэн сумаас түлшний зориулалтаар 2000 м3 Шинэс мод, өөрийн сумаас 50 м3 Бургас бэлтгэх хуваарь батлагдсан. Баруунбүрэн сумаас 39 иргэн 120 м3 түлшний мод, 9 иргэн 18 м3 гишүү бэлтгэж тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан.

Баруунбүрэн сумаас мод модон материалын гарал үүслийн гэрчилгээгүй мод тээвэрлэсэн Баруунбүрэн сумын харьяат 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 50.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцсон.

Бог малын хээлтүүлэг зохион байгуулалтын хүрээнд 42613 толгой хээлтэгчийн 34173 буюу 80.2 хувийг хээлтүүлт хамруулах ажлыг зохион байгуулаад байна. Францын түргэн өсөлттэй махны үүлдрийн нарийвтар ноост хонины хээлтүүлэгчийг хонин сүргийн хээлтүүлэгт ашиглах ажлыг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон “МАН-н эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-тэй хамтран зохион байгуулж 23 өрхийн мал сүрэгт дур зоргийн хээлтүүлэгт ашиглаж байна. “Орхон” үүлдрийн хонь үржүүлж буй “Мангирт трейд” ХХК болон малчин 7 өрхийн эм хонинд “Орхон” үүлдрийн 25 хуцыг хээлтүүлэгт оруулаад байна.

Хөдөө Аж Ахуйн Дээд Сургуульд 1879 тн, гурилын үйлдвэрт 4298,86 тн, спиртийн үйлдвэрт 60 тн, тэжээлд 1140 тн улаанбуудайг борлуулаад байна. Улаанбуудайн 650 тн үр нөөцлөлт байгаа бол борлуулагдаагүй 869 тн улаанбуудай байна.

Тарималын төрөл	Тариалсан талбай га	Хураасан талбай га	Хураасан ургац /тн/	Га-ийн ургац	Ургац алдсан талбай	Хураалтын талбай
Улаан буудай га	8959	8959	8897,2	9		100
Бусад үр тариа	237	237	266,2	11,2		100
Тосны ургамал	2912	2812	787,1	3		100
Тэжээлийн ургамал	1469	1469	1855,5	13		100
Төмс	370	270	3240	120	100	100
Хүнсний ногоо	263	212	2684,9	120,6	50,8	100
Бэлтгэсэн уринш /га/	11796					

/Ургац хураалтын эцсийн мэдээг харуулав./

Орхонтуул сум:

Тус суманд малын гоц халдварт Шүлхий өвчин бүртгэгдэж хорио цээрийн дэглэм тогтоож ажилласан боловч нөхцөл байдал хүндэрч өвчлөл нэмэгдэх болсон тул сумын Онцгой комиссын 05 тоот тогтоолоор хатуу хөл хорио тогтоож 14 хоногийн хугацаанд мал, мах гадагш гаргахыг хориглож, Шүлхий өвчний талаарх мэдээ тайланг Аймгийн Онцгой комисс болон аймгийн Мал эмнэлгийн газарт өдөр бүр хүргүүлэн ажиллаж байна. Шүлхий өвчний өвчлөлийн бүс газарт Хяналтын постыг ажиллуулж нийт 126 тээврийн хэрэгслийг бүртгэлжүүлэн ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажиллалаа.

Шүлхий өвчин гарсантай холбогдуулан мал бүхий, малчин иргэддээ мэдэгдэл зөвлөмжийг нийт 54 айл өрх, 4 аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлж, нийт 40 өрхийн 456 үхэр болон бог малд гоц халдварт А01 өвчний шинж тэмдэг илэрч, ээмэгжүүлэн бүртгэлжүүлэн ажиллалаа.

11 дүгээр сарын байдлаар 344 өрхийн 11642 үхэр, 58265 хонь, 40984 ямаа, 364 гахай нийт 111255 толгой мал, амьтныг вакцинжуулалтад хамруулсан бөгөөд бог тун 97763 мл, үхэр тун 22716 мл нийт 120479 мл тун /хорогдол 1079мл/-г зарцуулсан байна.

Хүний Эрхийн Үндэсний комиссын Сэлэнгэ аймаг дахь ажилтан, ГБХЗХГ-ын хамтарсан баг төр төсвийн байгууллагын албан хаагчдад “Жендэрийн тэгш байдал” сэдвээр сургалтыг зохион байгуулж сургалтад нийт 59 албан хаагч хамрагдсан байна.

Сайхан сум:

“Бүх нийтийн их цэвэрлэгээ” аяны хүрээнд бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төр, төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан 47.5 тн хог хаягдлыг хогийн цэг рүү тээвэрлэсэн.

Сумын Засаг даргын Тамгын газар, Хот тохижилтын газар, Сууц өмчлөгчдийн холбоотой хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтарсан байдлаар гаргах, иргэдтэй хамтран ажиллах тухай хэлэлцэн, Хог хаягдлын тухай хууль, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн хүрээнд танилцуулга хийгдлээ. Авлигын эсрэг гарын авлага 30 ширхгийг тараан ажиллалаа.

Энэ онд сумын хэмжээнд 28 аж ахуйн нэгж байгууллага, 15 иргэн нийт 16126.54 га-д тариалалт хийснээс үр тарианы талбайд улаанбуудай 11342,9 га, тэжээлийн ургамал 1361,74 га, рапс 2748,9 га, овьёос 673 га, төмс хүнсний ногоо 5 аж ахуйн нэгж байгууллага, 65 иргэн нийт 511,8 га буюу төмс 250 га, хүнсний ногоо 261,8 га-д тариалж ургац хураасан байна.

Сумын нийт Улаанбуудайн борлуулалт / хүснэгтээр/

№	Үтрэмд байгаа будаа /тн/	ХААДСан /тн/	Өөрийн үр /тн/	Тэжээлд /тн/	Спиртийн үйлдвэрт /тн/	Гурилын үйлдвэрт /тн/	Сумын нийт дүн /тн/	Сумын дундаж /цн /
1	2500	2050	1450	1150	850	6870	14870	13,5

Ургац хураалтын мэдээ /Төмс хүнсний ногоо/

№	Тарималын төрөл	Хураах талбай га	Хураасан талбай га	га-ийн ургац	Бүх ургац тн
1	Төмс	250	250	120	2520
2	сонгино	27	27	110	297
3	сармис	7	7	120	84
4	лууван	102	102	120	1224
5	тарвас	6.4	6.4	180	115.2
6	өргөст хэмх	5.1	5.1	150	91.7
7	улаан лооль	1.4	1.4	120	26.6
8	байцаа	21	21	120	252

9	<i>шар манжин</i>	79.9	79.9	120	958.8
10	<i>хүрэн манжин</i>	12	12	130	156
нийт дүн		261.8	261.8	120.2	3205.3

Суманд мал, амьтны гоц халдварт А01 /шүлхий/ өвчний сэжигтэй шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны А/161 тоот захирамжаар суманд Хорио цээрийн дэглэм тогтоон хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумын малчин, мал бүхий 20 өрхийн 153 үхэрт сэжигтэй шинж тэмдгээр илэрсэн бөгөөд уг айл өрхүүдэд нийт 6053 мал, амьтныг урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулж, 56225 м2 газарт, Улс, хот хоорондын дамжин өнгөрөх хатуу хучилттай зам дагуу 4 цэгт ариутгал халдваргүйжүүлэлтийг хийн ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Бичил хорооллуудын дунд тохижилт, ногоон байгууламж, авто зогсоол шинээр хийх ажилд хяналт тавин ажиллахад гүйцэтгэл 80 хувьтай байна.

Сумын хэмжээнд 11 дүгээр сарын байдлаар 4 удаагийн давтамжтайгаар нийт 38 аж ахуйн нэгж байгууллага 111,197 м2, нийтийн эзэмшлийн 207228 м2, халдвартай бүсийн ариутгал 3092 м2, талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийн ажилласан.

Шүлхий өвчин илэрсэнтэй холбогдуулан сумын хэмжээнд мах болон малын гаралтай бүтээгдэхүүн борлуулдаг цагаан идээ, махны нийт дэлгүүрт 2 удаагийн хяналт шалгалтыг хийн ажиллалаа.

Сант сум:

Сумын хэмжээнд 405 малчин, мал бүхий өрхийн нийт 102230 толгой мал түүний дотор тэмээ 6, адуу 5599, хонь 46814, ямаа 36599 толгой мал өвөлжихөөр бэлтгэл хангаад байна. Бэлчээрийн хүрэлцээ хангамж 88 хувь, малчдын түвшинд бэлтгэх 6735 тн өвснөөс 6075 тн, 2694 тн үйлдвэрийн тэжээл бэлтгэхээс 2025 тн бэлтгэж 85,7 хувь, сумын аюулгүй нөөцөд 100 тн өвс, 47,4 тн-ыг, 30 тн үйлдвэрийн тэжээл бэлтгэхээс 25 тн-ыг тус тус бэлтгэж 65,3 хувь, иргэд бизнесийн зориулалтаар 710,8 тн өвс бэлтгэж 110 тн-ыг борлуулсан. Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажил 90,3 хувийн дүнтэй байна.

Аймгийн ОНХС-аас зарлагдсан “Герефорд” бухын тендерээр нийлүүлэгдэх бухын чанарт хяналт тавьж 19 бух шилж, цусны дээжийг итгэмжлэгдсэн лабораторид хүргүүлсэн болно.

Сумын нутаг дэвсгэрт малын гоц халдварт шүлхий /А01/ өвчний халдвар илэрч сумын Засаг даргын 2021 оны А/138 тоот захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоогоод байна. Халдварын тархалт нэмэгдэж байгаагийн улмаас сумын Онцгой комиссын шийдвэрээр 11 дүгээр сарын 24-ний өдрийн 06.00 цагаас эхлэн 7 хоногийн хугацаанд сумаас гарах, орох хүн, мал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглолоо.

5 өрхийн 134 үхэр өвчилж, эмчилгээ хийснээр 60 үхрийн шинж тэмдэг арилаад байна. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 100 өрхийн 8319 малд хийгээд байна.

Сумын хэмжээнд хууль бус ангийн эргүүл, хяналтын ажлыг зохион байгууллаа.

Ахуйн зориулалтаар ан амьтан агнах эрхийн бичгийн зөвшөөрөл /загас 50ш, зэрлэг гахай 4, саарал чоно 1, бор гөрөөс 27/ иргэнд олголоо.

Мод бэлтгэх эрхийн бичгийг 38 иргэнд олгож улсын төсөвт 648280 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжид 63000 төгрөг, нөхөн сэргээлт 77000 төгрөг, талбай тусгаарлалтад 56000 төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Ойн тухай хууль зөрчсөн 1

үйлдлийг шалган шийдвэрлэж, 50.000 төгрөгийн шийтгэл, 380.094 төгрөгийн нөхөн төлбөр оногдуулсан.

Аж ахуй нэгжийн улсын ээлжит тооллогыг сумын Засаг даргын 2021 оны А/131 тоот захирамжийн дагуу зохион байгуулж, суманд бүртгэлтэй 68 аж ахуй нэгжийг хамруулахаас 67 аж ахуй нэгж хувиараа хөдөлмөр эрхлэгч 14 хамрагдаж тооллогыг хамрагдалт 98,6 хувьтай явууллаа.

Монгол Улсад худалдааны байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой, Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд суманд худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын гадна тохижилт, орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээний хүрээнд “Жижиглэн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний MNS5021-1:2019 стандартын дагуу гадна гэрэлтүүлэг тавих, ажиллах цагийн хуваарь болон гадна хаяг шинэчлэх, телекамерын ашиглалт ажиллагааг сайжруулах тухай хугацаатай үүрэг даалгавар өгөн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Зэвсэгт хүчний 336 дугаар ангиас 2021 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн алба хаагчдын тангараг өргөх ёслолын ажиллагааг цахимаар зохион байгуулж, арга хэмжээнд сумаас цэргийн албанд татагдсан 5 иргэний ар гэрийн төлөөллийг хамрууллаа.

Сүхбаатар сум:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын хуралдааны тэмдэглэл, тогтоол, тушаал, Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын баталсан тушаал шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн Сүхбаатар сумын ЗДТГазарт тандалт судалгааны баг ажиллаж 11 дүгээр сард нийт **649** иргэдээс тандалт судалгаа авч Өрхийн эрүүл мэндийн төвтэй холбон зуучлах, эмийн багц тараах, тухайн халдвар авсан иргэний ойрын хавьтал болсон иргэдийг ПСР шинжилгээнд хамруулан ажиллаж байна.

Сумын Засаг даргын “Нэмэлт дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай” захирамжийн хэрэгжилтийг ханган аж ахуйн нэгж, байгууллагад хуваарь гарган дархлаажуулалтыг явуулсан. Сумын хэмжээнд 3-р тунгийн дархлаажуулалт 40 хувьтай байна.

Долоо хоногийн 1,3,5 өдөр бүр ПСР шинжилгээний баг ойрын хавьтлын шинжилгээнд явж байна. ӨЭМТ бүрд түргэвчилсэн шинжилгээ өдөр бүр авч байна.

Сумын аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээнийг зохион байгууллаа.

Сүхбаатар сумын иргэдийг түлшний модоор хангах зорилгоор Түшиг, Ерөө, Хүдэр сумдтай хийсэн гэрээний дагуу түлшний мод бэлтгэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Мөн тус суманд түлээ, нүүрс борлуулах 2 цэг ажиллаж байна. Хүдэр сумын “Хүдэртэйн буян” ХХК-ий хүсэлтийн дагуу Сүхбаатар сумын иргэдэд бэлтгэсэн түлшний мод нийлүүлэх саналыг дэмжин Хүдэр сумаас тус сумын иргэдийн түлшний хэрэгцээнд зориулан 1000 м3 түлшний модыг тус компаниар бэлтгүүлэхээр гэрээ байгууллаа.

Жил бүрийн 11 дүгээр сарын 19-ний өдөр буюу “Дэлхийн жорлонгийн өдөр” –ийг угтан Сүхбаатар сум хэмжээнд “Эко жорлон Эрүүл хөрс” уриан дор эко жорлон ашиглагч иргэдийн туршлагыг иргэдэд түгээх зорилгоор Салхит 3-р багийн иргэн Э.Санчир, Д.Бат-итгэл, Баянхан 4-р багийн иргэн н.Санаа-амар, Боргүвээ 5-р багийн иргэн н.Цогтбаатар, Б.Хос-шагай нараас ярилцлага авч “Сэлэнгийн мэдээ” сонинд

нийтлүүлсэн. Мөн “Эко жорлон” нь эдийн заагт болоод эрүүл мэндэд тустай зэрэг олон давуу талын харуулсан дүрст сурталчилгаа болон зураг сурталчилгааг Сүхбаатар сумын цахим хаягаар дамжуулан түгээн ажиллалаа.

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 6100, 6152 тоот албан бичгийн дагуу соёл урлаг, үзвэр үйлчилгээ, спортын үйл ажиллагааг үе шаттайгаар нээсэнтэй холбогдуулан дээрх үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдтэй хариуцлагын гэрээ байгууллаа.

Австри улсын Засгийн газрын хөрөнгөөр “Дэд бүтэц” төслийн хүрээнд 800 ширхэг гэрэлтүүлэг хийгдэж байгаатай холбогдуулан Бор гүвээний 5-р баг, Буур хээрийн 8-р баг, Хонгор морьтын 1-р багуудад хийгдэж байгаа гэрэлтүүлгийн ажилд хяналт тавьж зайлшгүй зам сэтлэх ажилуудад хяналтыг тавьж замыг сэтлүүлэн “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-иар хийж гүйцэтгүүлэн ажиллаж 795 ширхэг гэрлийг асаах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хийж байна.

Мөн аймгийн болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилуудад холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ашиглалтад оруулах ажлыг хийж байна. Үүнд:

1. Баянхан 4-р багт тоглоомын талбай /Орон нутгийн хөгжлийн сан/
2. Буур хээрийн 8-р багт тоглоомын талбай /Орон нутгийн хөгжлийн сан/
3. Баянхан 4-р багт тоглоомын талбай /Орон нутгийн хөгжлийн сан/
4. Бор гүвээ 5-р багт тоглоомын талбай /Орон нутгийн хөгжлийн сан/
5. Орхон 6-р багт гэрэлтүүлэг /Орон нутгийн хөгжлийн сан/
6. Орхон 6-р багт явган хүний зам 390м урт 550 м2 /Аймгийн хөрөнгө оруулалт/
7. 1-р сургууль, Спорт сургуулийн дотуур байрны засвар /Аймгийн хөрөнгө оруулалт/
8. 1-р цэцэрлэгийн гадна талбайд тоглоомын талбайн тохижилт /Орон нутгийн хөгжлийн сан/

Сүхбаатар сумын ИТХ-ын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргаас сум болон багийн хамтарсан багийн дарга нартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, сайжруулах чиглэлээр “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” талаар сургагч багш Б.Цэцэглэн, “Сэлэнгэ амьдрах сайхан” ТТБ-ын сургагч багш Б.Ганбат “Гэр бүлээ хайрлая” сэдэвт гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар сургалтад 8 багийн Засаг дарга, нийгмийн ажилтан нар хамрагдсан байна. Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг хөршийн холбоогоор илрүүлэх таслан зогсоох талаар иргэдтэй санал бодлоо солилцон 10 иргэнтэй ярилцлага хийлээ.

Түшиг сум:

2021 оны ургац хураалтын эцсийн мэдээ үр тариа 8225 га талбайгаас 13358 тн хураан авч, үүнээс: Улаанбуудай 7119 га талбайгаас 11605 тн, Арвай 595 га талбайгаас 1120 тн, Овьёос 511 га талбайгаас 633 тн тус тус хураан авч, Нэгж га-с 16,2 цн-тэй байна. Мөн тэжээлийн ургамал 81 га талбайгаас 66 тн, Рапс 2785 га талбайгаас 1860,4 тн ургац хураан авсан.

Сумын хэмжээнд төмс 17 га талбайд тариалж 194 тн ургац хураан авч, хүнсний ногоо 20,7 га талбайгаас 151,6 тн хураан авч, Үүнээс: Сонгино 4 га талбайгаас 32 тн, лууван 4 га-с 27 тн, байцаа 4 га-с 31,2 тн, шар манжин 2,5 га-с 20 тн, улаан манжин 2,6 га-с 20,8 тн, улаанлооль 0,5 га-с 2,5 тн, өргөст хэмх 1,3 га-с 9,1 тн, тарвас 0,5 га-с 2,5 тн, эрдиск 0,3 га-с 1,5 тн, сармис 1 га-с 5 тн тус тус хураан аваад байна.

Сумын хэмжээнд улаанбуудайн борлуулалт: Гурилын үйлдвэрт 2725 тн, ТЭДС-нд 2341 тн, тус тус хийгдсэн байна. Мөн 2022 оны тариалалтад 1031 тн улаанбуудайн үр нөөцлөөд байна.

Сумын хэмжээнд адууны мах 720 кг, үхрийн мах 820 кг, хонины мах 85 кг, хонь 103, адуу 12, үхэр 29, ямаа 10 толгой мал, мах түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гарал үүсэл, ариун цэврийн гэрчилгээ олгосон.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлагыг 110 малчин болон мал бүхий айл өрхүүдэд тараан ажилласан.

Сумын хэмжээнд Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын 1-р тунд 1107, 2-р тунд 1023, 3-р тунд 552 иргэнийг хамруулсан байна.

Дээд шатны байгууллагад хүргэж эмчилсэн 169, ЭМС-ийн А/239 тоот тушаалын дагуу гэрээр тусгаарлан эмчлэгдэн гарсан 122 иргэн үүнээс 0-18 насны 21 хүүхэд, үүнээс сургуулийн сурагч 19 гэртэй байдаг 2 хүүхэд тус тус бүртгэгдэж эмчлэгдсэн байна. Гэрээр тусгаарлан эмчлэгдэж буй 20 иргэн үүнээс 0-18 насны 7 хүүхэд бүгд ЕБС-ийн сурагч байна.

Зүүнбүрэн сумын иргэдэд галын түлээний мод олгох ажлыг зохион байгуулж хяналт тавин ажиллаж байна 11 дүгээр сард 225 м3 нарс модыг олгоод байна.

“Шар нарст” ХХК-ий байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Байгаль орчны газарт тайлагнасан бөгөөд 98,1 хувьтай үнэлэгдсэн.

Сумын иргэдэд ойн санд цэвэрлэгээний ажил хийх зориулалтаар түлээний мод олгож хяналт тавин ажиллаж өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах үүднээс галын түлээний 85 хувийг бэлдүүлээд байна.

Хушаат сум:

Сумын Онцгой комисс цаг үеийн байдалтай холбогдуулан 3 удаа хуралдаж Шүлхий өвчний үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сумын 3 өрхийн 33 үхэрт шүлхий өвчний шинж тэмдэг илэрч өвчлөөд байна. Голомтын бүсэд байгаа 3 өрхийн 1418 толгой малыг голомтын бүсээс гаргахгүй байх арга хэмжээ авч ажилласан.

11 дүгээр сарын байдлаар 79 өрхийн 2375 үхэр, 3654 хонь, 2921 ямаа, 56 гахай нийт 9000 толгой мал, амьтныг урьдчилан сэргийлэх вакцинд хамруулаад байна. Цаашид вакцинжуулалтад нийт 27557 толгой малыг хамруулахаар ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2021 оны “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” А/104, А/110, “Шүлхий өвчнөөс сэргийлэх яаралтай дархлаажуулах ажлыг зохион байгуулах тухай” А/105 тоот захирамжуудын хэрэгжилтийг ханган Орхон голын гүүрэнд хяналтын пост 1, голомтын бүсэд байнгын пост 2 байгуулж, хөдөлгөөнт эргүүлийг оройн цагаар ажиллуулж байна.

Сумын хэмжээнд 11 дүгээр сард ковидын тандалтын шинжилгээг 138 иргэнд түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийж 59 иргэнээс /Ковид-19/ халдвар илэрсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэг болон Ерөө, Жавхлантын ковидын тасагт 32 иргэн эмчлэгдэж, гэрийн эмчилгээнд 27 иргэн хамрагдсан. 52 өрхийн 75 иргэн гэрийн тусгаарлалтад орсон байна.

Ариутгал халдваргүйтгэл төрийн байгууллагад 46800 м2, Хүнсний худалдаа үйлчилгээний байгууллагад 858 м2, хүнсний биш худалдааны газруудад /ШТС, Банк/

872 м2 талбайд хийгдсэн. Санамж сэрэмжлүүлэг цахимаар 8 цахим хуудсаар 12 удаа мэдээлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 19 дэх жилдээ зохион байгуулагдаж буй Иргэний андгай өргөх ёслолын арга хэмжээг зохион байгууллаа. Нийт 16 нас хүрсэн 8 сурагч иргэний андгай өргөн батламж, иргэний үнэмлэхээ гардан авлаа.

Ургац хураалтын эцсийн мэдээгээр улаанбуудай 10444 га-с тариалалт хийж 1780 га ургац алдсан 8664 га-н ургац 14582 тн 17,2 цн, рапс 3725-2114 га-н ургац алдаж, 1611 га-с 1367 тн, 8 цн ургац, Арвай 1845-439 га ургац алдаж, 1396 га-с 1319 тн 9 цн ургац, овьёос 93-50 га ногоон тэжээлд шилжин 43 га-с 80 тн, 19 цн, тэжээлийн ургамал 865 га-с 2161 тн, 25 цн, маалинга 530-208 ургац алдаж, 322 га-с 488 тн 25 цн, төмс 244,8-34,7 га-н ургац алдаж, 210,13-3230,2 тн төмс хураан авсан.

14465 тн улаанбуудайгаас үрэнд 1350 тн, тэжээлд 1780 тн, ХААДС-нд 2637 тн, гурилын үйлдвэрт 7180 тн, үтрэмд байгаа 1518 тн тус тус хуваарилалт хийгдсэн.

Аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах зорилгоор “Нэг суурин-Нэг бахархал аян”-ыг удирдамж хавсралтын дагуу судалгааг хийж танигдаагүй бүтээгдэхүүнийг гаргах судалгааг явуулж байна.

Сумын Цагдаагийн хэсэгтэй хамтран хууль бус ан, агнуураас урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалтыг сумын 2-р багийн нутагт 2 удаа хийж 2 иргэнд Зөрчлийн тухай хуулиар 600.0 төгрөгийн торгууль, 26000 төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, 2 ширхэг завь, 3 ширхэг тор, 2 ширхэг уурга, 10 ширхэг загас тус тус хураан авч улсын орлого болгосон.

Хүдэр сум:

2021 оны байдлаар суманд нийт 21 гэмт хэрэг бүртгэгдснээс залилах гэмт хэрэг 5 бүртгэгдсэн байна. Гэмт хэргийн шалтгаан нь цахим орчинд бараа материал худалдан борлуулах, иргэний цахим хаягийг хакердаж нэвтрэх зэрэг зөрчлүүд байгаатай холбогдуулан сумын ГХУСАЗСЗ, Хамтарсан багтай хамтран ЕБС-ийн IX-XII ангийн сурагчдын дунд “Цахим орчны зохистой хэрэглээ гэж юу бэ?”, “Цахим орчин дахь эрсдэлээс өөрийгөө хамгаалах нь”, “Цахим орчныг ухаалгаар ашиглах нь” сэдвүүдээр илтгэлийн уралдаан зохион байгуулж 4 баг оролцож 1,2,3-р байр эзлүүлэн мөнгөн шагналаар урамшууллаа.

Хүний эрхийн үндэсний хорооны Сэлэнгэ аймаг дах төлөөлөгч “Жендерийн үндсэн ойлголт, онол хандлага” сэдвээр сургалтыг зохион байгуулж 35 албан хаагч хамрагдсан.

Сумын ЗДТГ, “Дэлхийн зөн Монгол” ОУБ-тай хамтран “Гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам” сэдвээр холбогдох албан хаагчид, иргэдийг оролцуулан сургалтыг зохион байгуулж 28 иргэн хамрагдсан байна.

2021 онд 5 аж ахуй нэгж 7025 га-д үр тариа тариалж 9462 тн улаанбуудай хураан авсан. Төмс 59 га-гаас 470 тн, сонгино 70 га-аас 75 тн, Байцаа 3,5 га-аас 30 тн, Лууван 5 га-гаас 50 тн, Хүрэн манжин 3га-гаас 26 тн, Өргөст хэмх 7 га-гаас 70 тн, улаанлооль 6 га-аас 60 тн, Чинжүү 2 га-аас 12 тн, Хулуу 1 га-аас 5 тн, Сармис 4 га-аас 22 тн, Шар манжин 5 га-аас 50 тн тус тус хураан авсан.

Хүдэр сумын хэмжээнд сумын нөөцийн өвс 450 боодол өвс байна.

11 дүгээр сард малын эрүүл мэндийн гэрчилгээ олгох цахим системд 152 удаагийн гэрчилгээг олгосон. Үүнд адуу 17, үхэр 67, хонь 70, ямаа 20, адууны мах 1670 кг, үхрийн мах 15000 кг, гахайн мах 360 кг, хонины мах 3538 кг, ямааны мах 216 кг, аарц 20 кг, сүү 60 л байна.

Сумын Засаг даргын А/63 дугаар захирамжийн дагуу “Хүдэрдэлгэр” МЭҮН нь “Бруцеллёзын тандалт 2021” шинжилгээнд бух 80, хуц 40, ухна 50 толгойг хамруулсан бөгөөд эдгээрээс бух 3, ухна 2 бүгд 5 толгой мал бруцеллёзоор эерэг /өвчтэй/ дүнтэй гарсан байна.

Сумын Мал эмнэлгийн Улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн хэсэгчилсэн хязгаарлалтын дэглэмийг Засаг даргын А/150 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хээлтүүлэгч мал нь эерэг дүнтэй гарсан малчин өрхөөр явж бруцеллёз өвчний хор уршиг халдварлалт хүнд учруулах эрсдэл зэргийн талаар яриа танилцуулга хийж ажилласны дүнд эерэг гарсан 5 хээлтүүлэгч малыг хэрэгцээлүүлэх, болон хөнгөлүүлж цаашид халдвар тархахаас бүрэн сэргийлсэн арга хэмжээ авч ажиллалаа.

Эрэн хайх аврах салбар, байгаль хамгаалагч нартай хамтран, хөдөөгийн 50 малчин өрхөөр орж, малын гоц халдварт А/01 өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Тайлант хугацаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Байгалийн нөөцийн хууль бус ашиглалт, олборлолтын зөрчлийг бууруулах арилгуулах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг 4 удаа хийсэн. Хяналт шалгалтад Хүдэр сумын нутагт төмрийн хүдэр олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Дархан төмөрлөг” ХХК, “Эрдэс майннинг” ХХК-иуд хамрагдсан. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар хугацаатай албан албан мэдэгдэл хүргүүлэн ажилласан.

Хяналт шалгалтын явцад Ойгоос мод бэлтгэх журам зөрчсөн 1 иргэнд ЗТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.9.10 дахь заалтаар хялбаршуулсан журмаар арга хэмжээ авч бэлтгэсэн модонд нөхөн төлбөр оногдуулсан.

Амьтны тухай хуулийн хэрэгжүүлэлтийг хангуулах зорилгоор сумын Баянцагаан 2-р багийн “Аягын мараа”, “Цувраа мараа” нэртэй газрууд болох хууль бусаар ан агнах зориулалттай газруудад хяналт шалгалтыг 1 удаа хийсэн. Хяналт шалгалтын явцад Улаанбаатар хотын 3 иргэний тээврийн хэрэгсэл болон галт зэвсгийн бичиг баримтын бүрдэлтийг шалгаж зохих зөвшөөрөлгүй амьтан агнахгүй байхыг анхааруулж ажилласан.

Ойгоос мод шилжүүлж авсан аж ахуйн нэгжүүдийн шороогоор дүүргээгүй гэх нүхний тоог газар дээр нь шалгах, үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор хяналт шалгалтын ажлыг хийхэд тус сумын Шанд /Тасархайн даваа/ нэртэй газрын 64-р хэсэглэлийн 23, 52, 30, 24 дугаар ялгарлаас “Форест докторс ХХК, “Амьд газар” ХХК, “Энх ногоон газар” ХХК, “Амьд төгөл” ХХК зэрэг 4 аж ахуйн нэгж 1120 ширхэг мод шилжүүлэн суулгах зөвшөөрөл авсан аж ахуй нэгжүүдийг оролцуулан Газар дээр нь тооллого хийхэд ухсан нүхний тоо 987 ширхэг тоологдсон. Ухаж авсан модны нүхийг шороогоор дүүргээгүй байсан аж ахуй нэгжүүдэд 7 хоногийн хугацаатай албан шаардлага хүргүүлэн ажиллаж байна.

/Ковид-19/ халдвараас сэргийлэх фэйзер вакцины I тунг 2 хүн, II тунг 9 хүн, III тунг 257 иргэнд тус тус хийгдсэн.

Коронавирус илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг 257 иргэнд хийж сэжигтэй илэрсэн 21 иргэний PCR сорьцыг баталгаажуулан, батлагдсан тохиолдлыг үнэлэн аймгийн ковидын тасагт 12, Дархан 4, Ерөөгийн ковидын тасагт 1, Жавхлантын эмнэлэгт 8 иргэнийг хүргэн ажилласан.

Гэрийн тусгаарлалтад байгаа 32 хүүхэд, 131 иргэнд эмийн багц тараан хяналт үнэлгээ хийн зөвлөгөө өгөн ажиллаж байна.

“Зүрх мартаггүй” төслийн санаачлалгч Б.Болдсайхан ахлагчтай “Хязгаараас чинад” баг хамт олон Хүдэр сумын ард иргэдэд үзлэг зохион байгуулж 18 хүүхэд, 24 насанд хүрэгчид нийт 42 иргэнийг үзэж оношлон 4 хүүхдийг яаралтай мэс засалд оруулахаар болсон.

Цагааннуур сум:

Коронавируст халдвар /Ковид-19/-с урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын Онцгой комисс, Шуурхай штабын бие бүрэлдэхүүн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажиллаж Засгийн газар, улс, аймгийн Онцгой комиссоос гаргасан албан даалгавар, тогтоол, шийдвэр, чиглэлийн дагуу ажиллаж байна.

Сумын Засаг даргын А/118 тоот захирамжийн дагуу “Цагааннуур ургац-2021” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн, оёдол, гар урлал, хүнсний ногоо, даршилсан ногоо, мод модон эдлэл зэрэг 7 төрлөөр 21 өрхийн үйлдвэрлэгч, 1 аж ахуй нэгж нийт 200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээ танилцуулсан.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 35,0 сая төгрөгийн өртөгтэйгээр Хуурч 2 дугаар багийн “Залуус” хороололд хүүхдийн тоглоомын талбай барих ажил 80 хувийн гүйцэтгэлтэй, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 200,0 сая, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 100,0 сая, нийт 300,0 сая төгрөгийн өртөгтэйгээр сумын төвийн 2,3 дугаар багийг холбосон 2,5 км автозамын үргэлжлэл 300м хатуу хучилттай замын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сумын Засаг даргын Тамгын газар, “Цагааннуур тохижилт” ОНӨААТҮГ-тай хамтран золбин нохой устгалын ажлыг зохион байгуулж 100 золбин нохой устгасан.

Мал амьтны гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумаас орох, гарах мал амьтдын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих 24 цагийн постыг Бүдүүний гүүрэнд ажиллуулж байна.

Дэлхийн алхалтын өдрийг тохиолдуулан “Амьдрал бэлэглэгч 10000 алхам” аян өрнүүлж ЕБС-ийн 12 дугаар ангийн сурагчидтай хамтран 9,5 км зайд алхлаа.

Сумын Засаг даргын 2021 оны А/128 тоот захирамжаар “Аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн улсын тооллого” зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, нийт 132 аж ахуй нэгж хамрагдаж аж ахуйн нэгжийн хамрагдалт 100 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэлт 154 иргэн хамрагдахаас 87 иргэн хамрагдаж 56.5 хувь хамрагдсан байна.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын явуулын үйлчилгээг суманд ажиллаж зорилтот иргэдэд сэтгэл зүйн болон хууль зүйн анхан шатны зөвлөгөө, сумын удирдлагуудад хүүхдийн эрх хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр цаашдын ажил арга хэмжээг төлөвлөх чиглэлд санал өгч, газар дээр нь зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Улаанбаатар хотод зохион байгуулагдаж буй “Мал-мах-идэш” арга хэмжээнд оролцох 31 малчин оролцуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Хуурайшилтын үед 51 өрхийн 105 иргэнд ой хээрийн түймэр гарахаас сэргийлэх санамж тарааж, гарын үсгийн баталгаа авсан.

“Бүтээлийн нуур” ХХК-тай хамтран сумын төвийн нэгдсэн хогийн цэгийн хог түрж, хог асгах талбай бэлдсэн.

Шаамар сум:

Монгол Улсын Засгийн газрын 105 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Түр журам батлах тухай” 46 дугаар тушаал, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 тоот хамтарсан тушаалыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн эрчимжүүлэх тухай” А/15 тоот захирамжийн хүрээнд Шаамар сум Дулаанхаан тосгоны төр, төсвийн нийт 32, худалдаа үйлчилгээний 18 байгууллагын нийт 21586,2 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажилласан.

Тус суманд 11 дүгээр сард нийт 2 тохиолдол бүртгэгдсэн. Коронавирусын батлагдсан тохиолдлыг насны ангиллаар авч үзвэл 18-45 насны 2 иргэн бүртгэгдсэн байна. Аймгийн Эрүүл мэндийн төвийн даргын албан тоотын дагуу Шаамар сумын Ковидын тасгийг буулгасан.

Монгол Улсын 16 нас хүрч байгаа өсвөр үеийн залуучуудад эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, төр улсаа эрхэмлэн дээдлэх, эх орон ард түмнийхээ өмнө хүлээх иргэний эрх хариуцлагаа ухамсарлах чин шударгаар амьдрах, түүх соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх зорилготойгоор “Иргэний андгай” өргөх ёслолын ажиллагааг зохион байгуулж, 14 сурагч оролцсон .

Шаамар сумын Дэлгэрхаан 1 дүгээр багийн иргэн Д.Бадрахын бага охин Б.Энгүүн нь төрөлхийн зүрхний гажигтай гэх оноштойгоор 2018 оноос эхлэн байнгын эмнэлгийн хяналтад байгаа бөгөөд Улаанбаатар хотод яаралтай хагалгаанд орох, хагалгааны зардалд нийт 17.000.0 төгрөг шаардлагатай болсон тул “Бяцхан охин Б.Энгүүнд амьдрал бэлэглэе” сайн үйлсийн зохион байгуулж ажиллалаа. Хандивын аянд нийт 9 төрийн байгууллага, 6 аж ахуйн нэгж байгууллага, холбоо нийт 255 гаруй ажилтан, албан хаагч, тэдний гэр бүлийн зүгээс 4.105.0 төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 6183 тоот албан бичгийн дагуу сумын Засаг даргын А/147 тоот захирамжаар мал амьтны гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын тарилгыг зохион байгуулж нийт 145 гахай, бод мал 3429, бог мал 6834 тус тус хамруулсан байна.

Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.5.1 дахь заалтын дагуу Шаамар сумын Засаг даргын Тамгын газар, хүүхэд хамгааллын байгууллагууд хамтран “**Гэр бүл хүүхдэд ээлтэй орчин байх**” хөтөлбөрийг боловсруулж сумын иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлж ажилласан.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА